

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН XXI ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

## НЭГ. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улсын Бага Хурлын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор Дорноговь аймгийн Сүмбэр сум, Шивээговь хороо, Улаанбаатар хотын Баянтал хороог нэгтгэн улсын зэрэглэлтэй Чойр хотыг байгуулжээ.

Улсын Их Хурлын 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар тогтоол гарч Чойр хотын хилийн цэсээр Говьсүмбэр аймаг 1994 оны 8 сард байгуулагдав.

### 1.1 Газар нутаг, байгаль цаг уур

Тус аймаг нь Монгол Улсын төвийн бүсийн Зүүн өмнөд хэсэгт ХӨ 46° 57' - ХӨ 47° 02', ЗУ 107° 57' - ЗУ 109° 04' хүртэл оршдог. 554,0 мянган га нутагтай, байрлалын хувьд Өмнө талаараа Дорноговь аймгийн Даланжаргалан, зүүн, зүүн хойд талаараа Хэнтий аймгийн Дархан, Дэлгэрхаан, баруун хойд, хойд талаараа Төв аймгийн Баян, Баянжаргалан, Баянцагаан, баруун ба баруун урд талаараа Дундговь аймгийн Цагаандэлгэр, Баянжаргалан сумуудтай хиллэж эдгээр аймгуудыг төвтэй холбосон ачаа зорчигч тээврийн авто замтай, олон улсын транзит төмөр замын сүлжээ бүхий аймаг юм.

Нутгийн байгалийн бүтцийн хувьд дов толгод бүхий хээр талын бүсэд оршдог.

Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1620 метр. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр. Өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -33 хэм, зуны улиралд хамгийн халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог.

Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг нь Говийн бүсийн дунджаас илүү юм. Тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй. Хонь, тэмээ, үхэр, ямаа, адууны аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой.

Усан хангамжийн хувьд өрөмдмөл, богино яндант, энгийн, бетонон хашлагатай худаг 246 байгаагаас Сүмбэр суманд 197, Баянтал суманд 15, Шивээговь суманд 34 байна. Бэлчээрийн усан хангамжинд зориулагдан Сүмбэр суманд 188, Баянтал суманд 8, Шивээговь суманд 28 бүгд 224 худаг ашиглагдаж байна. Тус аймгийн нутагт байнгын ундрагатай Хулгар, Уулзвар, Цоорхой, Хүхээ, Цагаан Ус, Уст ханан, Шивээ зэрэг 43 ил задгай горхи булаг шанд бий. Нутгийн баруун хойд талаар хялгана, харгана, баруун өмнөд талаар бударгана дэрс, зэрэг голлосон тойрмын ургамал голлох бөгөөд бэлчээрийн өвөл хаврын даац нь дунджаар 08-1,0 центнер га, зун намрын даац нь 2,5-3,0 центнер га-гийн нөөцтэй тул 80,0 мянгаас илүү малыг бэлчээрээр хангах боломжгүй юм.

Тус аймгийн Чойрын богд, Сансар уулын орчимд 100 гаруй аргаль, 10 гаруй янгир нүүдэллэн амьдарч байгаагаас гадна Халзангийн говь, Хүрэн дух, Баянхошууны говь, Нүхэн сондуул, Тогоогийн булаг орчимд хар сүүлт, цагаан зээр амьдарч, хар сүүлтийн сүргийн бүтэц нь 4-8 орчим, цагаан зээрийн сүргийн бүтэц нь 50-300 орчим буюу 2000 оны судалгаагаар 6000 гаруй байна гэсэн тооцоо гарсан. Хээрийн тарвага нэг га-д 42 коэффициент байгаа нь улсын дундаж хэмжээнд байна. Жигүүртэн шувуудаас талын бүргэд, элээ, харцага, сар, ууль, ховордсон шувуудаас цармын бүргэд, идлэг шонхор зэрэг шувууд уул, хад асга бүхий газар үүр засан амьдардаг.

Хаврын өдрийн урт 10 цагаас бага, цэлмэг өдөр 7 өдрөөс бага, бүрхэг өдөр 5-аас бага, зуны өдрийн урт 10 цагаас бага, зуны бүрхэг өдөр 5-аас бага, цэлмэг өдөр 3-аас их, намрын өдрийн урт 8 цагаас бага, бүрхэг өдөр 3-аас бага, цэлмэг өдөр 13-аас

**Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот**

бага, өвлийн өдрийн урт 7 цагаас бага, 1-р сарын агаарын дундаж температур  $-25^{\circ}$ -аас бага, 7 сарын агаарын дундаж нь  $10^{\circ}$ -аас бага, агаарын жилийн дундаж хэм нь  $15^{\circ}$ -аас бага, жилийн үнэмлэхүй их хэм нь  $35^{\circ}$ -аас бага байдаг. Өвөлд орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас тогтох хугацаа 11-р сарын 21-12-р сарын 1, цас арилах хугацаа 3-р сарын 15 хүртэл үргэлжилдэг.

Салхины хамгийн их хурд 25 м/секунд. Салхины чиглэлийг авч үзвэл 1-р сарын Розагаар хойд, баруун хойд, зүүн зүгийн салхи голлодог. Салхигүй тохиолдол 22 хоног. Салхины дундаж хурд нь хойд зүгийн салхи 2-4 м/сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/сек, баруун хойд зүгийн салхи 2-4 м/сек байдаг. 7-р сарын салхины розаг авч үзвэл салхигүй хоног 21, хойд зүгийн салхи 18 м/сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/сек, зүүн хойд зүгийн салхи 2-4 м/сек, баруун урд зүгийн салхи 2-4 м/сек байдаг.

Аймгийн нутагт хүйтэвтэр хоногийг авч үзвэл хамгийн олон нь 122 хоног, хамгийн цөөн нь 95 хоног, хүйтэрдэггүй хоног 80-100 хоног байдаг. Энэ нь байгаль цаг уурын хувьд гадаадын иргэд ажиллаж амьдрахад тохиромжтой нөхцөл юм.

### **1.2. Хүн ам**

Тус аймаг нь 12121 хүн амтай. Хүн амын 50,9 % эмэгтэй, 49,1 % нь эрэгтэй. Хүн амын 58,5 % нь аймгийн төвд, 30,8 % нь сумдын төвд, 10,7% нь хөдөөд амьдардаг.

Хүн амд үйлчлэх нийгмийн чиглэлийн үйлчилгээний салбарууд хөгжсөн учраас зэргэлдээ аймгуудын иргэд шилжин суурьших хандлага жилээс жилд нэмэгдэж байна.

Аймгийн хүн амын 35,4 % нь 16-35 насны залуучууд байдаг. ЕБС-ийн 5 сургуулийн 93 бүлэгт 2934 хүүхэд суралцаж, анги дүүргэлтийн дундаж 37,1 %, нэг багшид ноогдох сурагчдын тоо 23,4 байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхитэй хайж бүртгүүлсэн ажилгүйчүүд 163 буюу ажилгүйдлийн түвшин 4,4 % байна.

Одоогоор бодит ажилгүйдлийн хувьд 2100 гаруй хүн тодорхой ажил эрхлээгүй байгаа юм.

Нийт ажилгүйчүүдийн 17,8 % нь дээд тусгай дунд, 8 % нь техник мэргэжлийн, 68,7 хувь нь бүрэн болон бүрэн бус дунд боловсролтой, 4,9 % нь бага боловсролтой, 0,6 % нь боловсролгүй иргэд байна.

Ажилгүйчүүдийн 54,6% нь эмэгтэйчүүд, 45,4% нь эрэгтэйчүүд байгаагаас насны ангилалаар 16-24 насных 30,1% 25-34 насныхан хамгийн олон буюу 38,1%, 35-44 насныхан 23,9%, 45-60 насныхан хамгийн цөөн буюу 7,9% байгаагаас үзэхэд хөдөлмөрийн идэвхитэй хүн ам, хөдөлмөрийн нөөцийн хувьд бололцоотой юм.

### **1.3 Эдийн засаг, дэд бүтэц**

Тус аймгийн нутаг дэвсгэр дээгүүр олон улсын Транзит төмөр зам болон агаарын /коридор/ зам дайран өнгөрдөг.

Ачаа тээврийн, иргэний зорчигч тээвэрлэх бүх төрлийн даацын онгоц хөөрч буух 3 км урттай, 72 м-ийн өргөнтэй 2 зурвас бүхий онгоцны буудалтай.

Монгол улсын хойд хилээс өмнөд хил хүртэл тавигдсан шилэн кабелийн шугамд холбогдсон. Тоон АТС-ын системд шилжсэн, хөдөлгөөнт холбоо суурилагдсан. Дэлхийн аль ч улс оронтой телефоноор болон интернетээр харилцах боломжтой.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Налайх - Чойрын чиглэлийн 200 км хатуу хучилттай зам барилгын ажил 2002 оны 05 сард эхэлсэн ба 2004 оны 06 сард ашиглалтанд орох юм.

Цахилгаан эрчим хүчний дамжуулах станц нь хүчин чадлынхаа 33 %-г ашиглаж байгаа нь цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэр нөөцтэй гэсэн үг.

Аймгийн төвийн усанд агуулагдах төмрийн хэмжээг багасгасан нөхцөлд үйлдвэрлэлийн буюу ундны усны хангалттай нөөцтэй болно.

Шивээ-Овоогийн уурхай одоогийн хэрэгжиж буй төслийн хүрээнд жилд 2,0 сая тн нүүрс олборлоход 100-аас доошгүй жил ашиглах нөөцтэй. Мөн ханын материалын тоосго үйлдвэрлэхэд тохирох шаврын нөөц бий.

Нефть хангамжийн газар Өмнөговь, Дундговь, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг шатахуунаар хангахад хүрэлцэхүйц шатах, тослох, материал агуулах тээвэрлэх боломжтой.

Өвс тэжээл хадгалах өндөр хүчин чадал багтаамж бүхий улсын нөөцийн газар ажиллаж говийн аймгуудыг өвс тэжээлээр хангаж байна.

Сүмбэр суманд одоогоор ашиглалтгүй байгаа материал техникийн хангамжийн газрын контор, агуулах, хашаа, ачаа татах салаа төмөр зам, Баянхайрхан ХК-ний граш, агуулах, Баянтал суманд байгаа онгоцны буудал, нэг нь 80х20м-ийн багтаамжтай 40 орчим төмөр агуулах ангоруудыг ашиглан бөөний худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах бүрэн бололцоотой. Энэ нь нэмэлт ажил хийхэд төсөв хөрөнгө зардал бага зарах магадлалтай.

Тус аймгийн төв нь Хэрлэн голоос 90 км, Дорноговь аймгийн Халзан – Уулын рашаан сувиллаас 60 км зайд оршдог бөгөөд орон нутгийн хамгаалалттай өндөр хадан хясаагаар хүрээлэгдсэн дотор эрхтнийг анагаах увьдистай Цоорхойн рашаан, Аргаль, янгир нутагшсан Чойрын богд уул, Эртний түүхт Зүүн Чойрын хийдийн туурь, Зараа хэмээх газарт байгаа эртний түрэгийн хүн чулуун хөшөө дурсгалууд зэрэг байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын цэвэр бодит өсөлт дунджаар 500 байна. Энэ хурдаар өсвөл 2020 он гэхэд тус аймгийн хүн ам 30000 хүрэх хэтийн төлөв ажиглагдаж байна.

Эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, бизнесийн таатай орчинтой, амьжиргааны өртөг харьцангуй хямд давуу талд татагдаж говийн бүсийн аймгуудын иргэдийн шилжилт суурьшилтын төв нь Говьсүмбэр аймаг болж хүн амын механик өсөлт тасралтгүй нэмэгдэх хандлагатай .

Тус аймагт барилгын үйлдвэрлэл явуулах, Говьсүмбэр, Дундговь аймгийн нутгийг дамжин орших Хараатын ураны хүдрийг ашиглах, олборлох, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс химийн үйлдвэрийг байгуулж керолин, кокс, шингэн болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортлох бололцоотой юм.

## **ХОЁР. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО**

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу байгальтай зохицсон соёл иргэншил төлөвшүүлэх, дотоод, гадаад, хүчин зүйлийг үр дүнтэй ашиглах замаар эдийн засгаа экологийнхоо даацад тулгуурлан сэргээн тогтворжуулж, иргэдийн аж амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөгжлийн урт хугацааны цэгцтэй бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү шаардлагыг үндэслэн боловсруулсан аймгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр нь ойрын ирээдүйд байгалийн баялаг, хүний хүчин зүйлийг зүй зохистой ашиглан, экологийн баримжаатай эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, нийгмийн дэвшлийг хангах талаар төрөөс

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичиг мөн.

**Хүнээ дээдлэх, хүнийг хөгжүүлэх, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эдийн засгийн бие даан хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалж, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүн бүхэн ая тухтай амьдрах экологийн эрүүл орчныг бүрдүүлэхэд тогтвортой хөгжлийн эрхэм зорилго оршино.**

Тогтвортой хөгжлийн стратегийн зорилт нь шинэ зуунд экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, уул уурхайн аж үйлдвэр өндөр хөгжсөн, 2020 оны түвшинд иргэдийн амьжиргааны хэвийн түвшинг баттай хангах, санхүү, эдийн засгийн хувьд өөрийгөө тэтгэх чадавхитай болгох явдал мөн. Энэхүү стратегийн зорилт нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар үйлдвэржилтийн түвшинг дээшлүүлэх, нөөц баялгийг үр ашигтай зарцуулах явдлыг хамарна. Цаашид хөгжин дэвжихийн үндэс нь юуны өмнө одоогийн байгаа давуу талдаа түшиглэн эдийн засаг, нийгэм, байгаль орчны тэргүүлэх чиглэлийг зөв тодорхойлж, экосистемийн даацад тулгуурласан эдийн засгийн өсөлтийг ханган хөгжүүлэхэд оршино.

Тогтвортой хөгжлийн Иоханнесбургийн даян дэлхийн чуулга уулзалт, 2002 онд болсон Монгол улсын үндэсний бага хурлын шийдвэр, тус аймагт эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зэрэгтэй уялдан 1997 онд батлагдсан аймгийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн чиг хандлага өөрчлөгдсөн тул шинэчлэн боловсрогдсон энэхүү хөтөлбөрийг 2003-2010 он, 2010-2020 он гэсэн 2 шатаар хэрэгжүүлнэ.

### **Нэгдүгээр үе шатны зорилго, зорилт**

**Зорилго:** Байгалийн нөөц, баялагтаа тулгуурлаж, экологийн тэнцвэрийг хангах нөхцлийг бүрдүүлэх, үйлдвэрлэл, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж улмаар тогтворжуулах, нутгийн захиргааны бүтэц, зохион байгуулалт, удирдлагыг боловсронгуй болгох замаар хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж “Сайн засаглал”-ыг бий болгон эдийн засгийн чөлөөт бүс байгуулах нь энэ шатны зорилго болно.

### **Зорилт**

- ◆ Хүн амын тогтвортой өсөлт, зохистой суурьшлыг хангаж, орон нутгийн хүн амын ердийн болон механик өсөлтийг тэнцвэржүүлэн нялхсын эндэгдлийг багасгах талаархи хөтөлбөр хэрэгжүүлэх, ядуурлыг бууруулах;
- ◆ Орон нутгийн нийгмийн халамжийн тогтолцоо бүрдүүлж, иргэдэд халамжийн үйлчилгээ үзүүлэх, бүтэн өнчин, тэнэмэл хүүхдийг асран хамгаалах, боловсрол олгох, аймаг, сумдад “ нийгмийн халамжийн сан “ байгуулж, хүртээмж, ашиглалтыг сайжруулах;
- ◆ Ажилгүйдлийн түвшинг 4,5%-иас хэтрүүлэхгүй байлгаж, ажлын байрны тоог нэмэгдүүлэх;
- ◆ Удирдлагын чадавхийг дээшлүүлж, нөөцийг бүрдүүлэх
- ◆ Аймгийн эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж, аж үйлдвэрийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж эдийн засгийн чадавхийг бий болгохын тулд дараах арга хэмжээ авах:
  - Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд техник тхнологийн шинэчлэл хийх ажлыг дуусгаж төслийн хүчин чадалд хүргэх

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- Малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг түлхүү хөгжүүлэх
- Зам барилгын материалын үйлдвэр байгуулж зах зээлд нийлүүлнэ.
- Шивээ-овоогийн нүүрсний уурхайг түшиглэн нүүрс-химийн үйлдвэр байгуулж ашиглаж эхлэх
- Малын өвчин анагаах керолин, кокс химийн болон бусад бүтээгдэхүүн нүүрснээс гарган авч дотооддоо хэрэглэх, экспортлох
- Аймгийн эрчим хүч, тээврийн үйлчилгээ, суурьшил, хүний нөөцийн ажиллах хүчний хангамж зэрэгтээ тулгуурлан орчин үеийн жижиг, дунд үйлдвэрийг байгуулах, ажлыг дэмжих
- ◆ Сүмбэр хонины удмын санг хадгалж, өмчийн хэлбэрийг зохистой шийдвэрлэн, үр ашгийг нь дээшлүүлэх
- ◆ Бэлчээрийн даац хэтэрч, цөлжилт, хөрсний эвдрэл үүсч байгаа газарт ногоон бүс, ойн зурвас байгуулах, экологи, эдийн засгийн боломжийг судлах, газрын хөрсийг нөхөн сэргээх, ахуйн хог хаяглыг ялгах, дахин боловсруулах үйлдвэрийн ажлын эхлэлийг тавих
- ◆ Иргэдийн ундны болон ахуйн хэрэгцээний усны нөөц хомсдохоос хамгаалах, бохирдлоос сэргийлэх, усны хатуулгийг бууруулах, чанарыг дээшлүүлэх, инженерийн хийцүүдийг сольж, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, усны хэрэглээнд хяналт тавих системтэй болж, зарцуулалтын хэмжээгээр төлбөртэй болох механизм бүрдүүлэх
- ◆ Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх
- ◆ Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах
- ◆ Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг зах зээлд ойртуулах үүднээс жижиг, дунд үйлдвэр хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлэх
- ◆ Хүн амын тогтвортой өсөлттэй уялдуулан хүнсний хангамж, үйлдвэрлэлийг сайжруулж, зохистой, соёлтой хэрэглээний харилцааг бий болгох зорилт дэвшүүлж шийдвэрлэх
- ◆ Төмс хүнсний ногоо тариалах, ахуйн үйлчилгээ явуулах, гахай, тахиа, мал маллах зэрэг аж ахуйг эрхлэх бодлого баримталж, үүгээрээ ядуурлыг саармагжуулж, аажмаар бууруулахад дэм үзүүлэх
- ◆ Бруцеллёз, сүрьеэгийн өвчлөлд тандалт судалгаа хийж, ДОХ, бэлгийн замын өвчинтэй тэмцэх арга хэмжээ авах, энэ талаархи дэлхийн эрүүл мэндийн болон олон улсын бусад байгууллагын төслийг дэмжин хэрэгжүүлэх
- ◆ Боловсролыг зөвхөн сургуулиар хязгаарлахгүй, сургуулийн өмнөх болон зайнаас олгох мөн түүнчлэн албан бус боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэх сургалт зэргээр хүн амын сургалтын асуудлыг цогцоор авч үзэж, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахад чиглүүлэх
- ◆ Газар тариаланг эрчимтэй хөгжүүлж, иргэдийн хүнсний ногооны хангамжийг 2005 оноос өөрсдийн хүчээр шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх
- ◆ Газар, түүний нөөцийн үнэлгээг нарийвчлан тогтоож, газрын харилцааны шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.
- ◆ Ашигт малтмал, ус, ан амьтан, ургамал зэрэг биологийн төрөл зүйлийг зүй зохистой ашиглах, хамгаалах, арга хэмжээг дэс дараатай авах
- ◆ Аймгийн төвд нийтийн ахуйн үйлчилгээний төвтэй болох
- ◆ Соёл спортын цогцолбор барих
- ◆ Бөөний худалдааны сүлжээ байгуулах

**Хоёрдугаар үе шатны зорилго, зорилт**

**Зорилго:** Нийгэм эдийн засгийн дэд бүтцийн чанар, хүртээмж, чадамжийг сайжруулж, экологийн тааламжтай орчинг бүрдүүлж, хүн амын зохистой суурьшил бий болгосноор

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот өмнөд бүсийн тэргүүлэх аймаг болох угтвар нөхцлийг бүрдүүлэх нь 2-р шатны зорилго болно.

## **Зорилт**

- Босоо тэнхлэгийн авто замыг түшиглэж авто аж ахуйг хөгжүүлнэ.
- Баянтал сумын нутаг дахь нисэх онгоцны буудлыг сэргээн тохижуулж, олон улсын нислэгийн чиглэлээр ашиглана.
- Зүүн Чойрын хийдийн туурь, Чойрын Богд уул, Цоорхойн рашаан зэрэг үзэсгэлэнт газруудыг түшиглэн жуулчны бааз бий болгоно.
- Олон улсын баталгаат агуулахын аж ахуй хөгжүүлнэ
- Нийгмийн эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны ажлыг хүчтэй болгон оюун ухааны хомсдолтой, эрхтэн согог хүүхэд төрөх нийгэм, биологийн үндсийг таслан зогсоох шат дараалсан арга хэмжээг авах
- Хүн амын ундны усны болон ахуйн усны хангамж, хүртээмж, эрүүл ахуйн шаардлагыг хангах, экологийн цэвэр орчин бүрдүүлэх, баталгаатай аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангах дэг журам баримтлан, энэ талаархи хяналтын механизм бүрдүүлэх, суурин газрын усны зарцуулалтыг тоолууржуулж, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах
- Иргэд хувьдаа тохилог орон сууц барих хөдөлгөөн өрнүүлэхийг дэмжин, орон сууцаар хангах
- Эрэлт ихтэй, тогтвортой ажлын байр нээх замаар хүн амын төв рүү тэмүүлэх хөдөлгөөнийг сааруулж, төв хөдөөгийн суурьшлын зохистой харьцааг барих
- Үйлдвэрлэл үйлчилгээний болон ахуйн хог, хаягдлын цэгийн тоог цөөрүүлэх, үүссэн хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах бага оврын үйлдвэр байгуулах төслийг сонгон шалгаруулж хэрэгжүүлнэ
- хүүхдийн клиникийн төв байгуулах, нарийн мэргэжлийн оношлогоо, эмчилгээний орчин үеийн аппарат, хэрэгслээр хангана
- сургуулиудыг материаллаг бааз, боловсон хүчнээр ханган, сургалтын орчны стандартыг бүрэн биелүүлнэ
- Техник технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлэн хэрэглэгчдийн техникийн сэтгэлгээг хөгжүүлж, автомат системтэй харьцаж сургана.
- Барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг нэмэгдүүлэн, хэрэгцээгээ хангаж, зах зээлд нийлүүлнэ
- Орон нутаг, бүс нутгийн хэмжээнд агаар мэндлыг хамгаалах, түүнд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах, шинэ техник технологийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах эдийн засгийн хөшүүрэг хэрэглэнэ
- Үер, ган зуд, хүчтэй цасан болон шороон шуурга, газар хөдлөлт зэрэг байгалийн төрөл бүрийн гамшиг мөн түүнчлэн хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд туслах тогтолцоо бий болгоно.

## **ГУРАВ. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

### **3.1 Хүн амын өсөлт, хөгжил**

#### **Үндэслэл**

Хүн амын жилийн дундаж ердийн өсөлтийн коэффициент 1,4. Хүн амын хувийг хөдөлмөрийн насны хүн ам, ? хувийг 0-15 насны хүүхэд, ? хувийг хөдөлмөрийн нас хэтрэгсэд эзэлдэг. Аймгийн хэмжээнд 3218 өрхтэйн 69,3 хувь нь аймгийн сумын төвд, 664 өрх буюу 22,6 хувь нь хөдөөд байна. Хүн амын 58,5 хувь аймгийн төвд, 30,8 хувь нь сумдын төвд, 10,7 хувь нь хөдөөд амьдарч байна. Нэг өрхөд дунджаар 4,2 хүн

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот ногдон, жилд 312 эх төрж, 81 хүн нас барж, хүн амын цэвэр өсөлт 231 болж, 1991 оноос хойш хүн амын тоо 4,9 хувиар өсөв. Төрөлт нас баралтын харьцаа 1997 оны түвшинд тогтвортой барьж байна. Хүн ам зүйн ачааллаар авч үзэхэд 3990 хүн тогтвортой хөдөлмөр эрхэлж байгаа нь хөдөлмөрийн чадвартай 1 хүн 3 хүнийг тэжээж байна гэсэн үг. Энэ нь 1997 оны үеийнхээс ахисан эерэг үзүүлэлт юм.

## **Зорилт**

Хүн ам зүйн зохистой бодлого явуулж, тогтвортой өсөлтийг ханган 2020 онд 30000-аас дээш хүн амтай болно.

## **Үйл ажиллагаа**

- Z Төвийн бүсийн хэтийн хөгжилтэй уялдуулан хүн амын өсөлтөд нөлөөлөх шилжилт хөдөлгөөнд эерэг нөлөө үзүүлэхүйц бодлого явуулах
- Z Угийн бичгийг хөтлөх ажлыг өргөн зохион байгуулах, энэ асуудлыг сургуулиудын хөтөлбөрт тусгах
- Z Хүн амыг гэр, тохилог орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлж, орон сууцны фондыг нэмэгдүүлэх
- Z Нийгмийн эмзэг хэсэг, эхчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрээс хөдөлмөр эрхлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх

### **3.2 Ядуурал, ажилгүйдлийг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах.**

#### **Үндэслэл.**

2002 оны байдлаар аймгийн хэмжээгээр нийт ядуу 1281 өрхөд 6630 хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 44,2 хувь, хүн амын 54,8 хувийг тус тус эзэлж байна.

Орлого багатай ядуу өрхийн 420 нь нэн ядуу өрх, 341 эмэгтэй ядуу орлого багатай өрхийг толгойлж байгаа бөгөөд үүнээс нэн ядуу өрх 160 байна.

2002 оны байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил идэвхитэй хайж бүртгүүлсэн ажилгүйчүүд жилийн эцэст 163, нийт ажиггүйчүүдийн 17,8 % нь дээд, тусгай дунд, 8 % нь техник мэргэжлийн, 68,7% нь бүрэн болон бүрэн бус боловсролтой, 4,9% нь бага боловсролтой, 0,6 % нь боловсролгүй иргэд байна.

Ажилгүйчүүдийн 54,6% нь эмэгтэйчүүд, 45,4% нь эрэгтэйчүүд байна. Насны ангилалаар үзвэл 16-24 насныхан 30,1%, 25-34 насныхан хамгийн олон нь буюу 38,1%, 35-44 насныхан 23,8%, 45-60 насны хүмүүс хамгийн цөөн буюу 7,9 % байна.

Нийт ажилгүйчүүдийн 10,4% нь ядуу, 64,4% нь нэн ядуу, бага насны хүүхэдтэй эхчүүд 25,1 %-ийг тус тус эзэлж байна.

Ажилгүйчүүдийн дунд мэргэжилгүй ба удаан хугацаагаар ажилгүй байгаа 35 хүртэлх насны хүмүүсийн тоо өндөр байгаа нь цэргээс халагдсан болон ЕБСургууль төгсөөд ажил сургуульгүй үлдсэн охид хөвгүүд хөдөлмөрийн зах зээлд шилжин ирж байгаатай холбоотой байна.

Хүн амын насны суваргаас харахад 1980-аад оны төрөлт өндөр байгаа нь энэ массаараа хөдөлмөрийн зах зээлд шилжин орж ажилгүйдлийн түвшин огцом өсөх хандлагатай байна.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурсанаар илэрч байгаа төдийгүй хоол тэжээлийн илчлэг дутагдсанаас эрүүл мэнд муудан элдэв өвчин эмгэгт нэрвэгдэх, оюуны хоосролд орох, хүүхэд сургууль завсардаж ёс суртахууны доройтолд орж элдэв янзын гэмт хэрэг өсөх зэрэг ноцтой үр дагаврууд бий болсоор байна.

МУЗГ-ын 2001 оны 108-р тогтоолоор Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2 дахь шатны хөтөлбөр болох **\*Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр\*** батлагдсаны дагуу аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Ядуурлаас үүдэн хүн амын тодорхой хэсгийн эрүүл мэнд доройтох, өөртөө итгэлгүй болох, гэр бүлийн хүрээн дэх хүчирхийлэл нэмэгдэх, амиа хорлох, сэтгэцийн гажиг нэмэгдэх зэрэг нийгмийн гаж үзэгдлүүд ч бий болох үндсэн нөхцөл бүрэлдэж байна. Иймд ядууралд хүргэж буй үндсэн шалтгаан, нөхцлийг илрүүлэх, үндсийг нь арилгах, хүн амыг материалын болон сэтгэлгээний ядуурал, ёс суртахууны доройтлоос хамгаалах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйл ажиллагааны гол чиглэл болгон дараах зорилтыг дэвшүүлж байна..

### **Зорилт.**

Аймгийн эдийн засаг, үйлдвэрлэлийн өсөлт, хөрөнгө оруулалттай уялдуулан ажлын байр, байнга өсөн нэмэгдэж байх бодлого барьж иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэн ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхитэй хүн амын 2.5 хувиас хэтрүүлэхгүй байх, хүний хөгжлийн хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэхэд оршино.

### **Үйл ажиллагаа.**

1. Хөдөлмөр эрхлэлт, өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2. Ажил идэвхитэй эрж буй хөдөлмөрийн насны иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн болон тухайн онд ЕБС-ийн 8,10-р анги төгссөн, хугацаат цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй иргэдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй байгаа мэргэжлээр мэргэшүүлэх шинэ техник технологи эзэмшүүлэх чиглэлээр сургалтын бааз бүрдүүлж цаашид чөлөөтэй хөрвүүлж ашиглах.

Малгүй өрхүүдийг малжуулах, газар тариалан эрхлүүлэх зэргээр өмч хөрөнгөтэй болгоход нь туслах ажил зохион байгуулах.

Ажлын байр шинээр бий болгож байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж, банкны зээл, төсөлд хамруулах бодлого барина.

Дэд бүтэц, зам харилцааны давуу талыг ашиглан хөрөнгө оруулалтыг түлхүү хийх бодлого баримтлах.

Бүс нутгийн бөөний худалдааны сүлжээ байгуулах.

### **3.3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах**

#### **Үндэслэл.**



Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Нийгэм эдийн засгийн хөгжилтэй холбоотой хүмүүсийн амьдрах хэв маяг өөрчлөгдөж /Нийт хүн амын 73,5% нь аймгийн төвд буюу Сүмбэр суманд,үлдсэн 26,5% нь хөдөөд амьдарч байна/

Зүрх судас,хоол боловсруулах эрхтний өвчин,зарим хорт хавдар,таргалалт,шүд цоорох,чихрийн шижин,бэлгийн замаар халдварлах өвчин зэрэг хүмүүсийн аж төрөх дадал хэвшилтэй холбоотой үүсдэг өвчнүүд нэмэгдэх хандлагатай байна.

Эрүүл мэндэд хор,аюул учруулах хог хаягдал,хот суурин газрын агаарын бохирдол,хооллох буруу дэглэм,биеийн жингийн илүүдэл,төрөл бүрийн нутагшмал болон халдваргүй өвчин, ид залуугаараа нас барах, сэтгэцийн эмгэгүүд зэрэг шинэ сөрөг үзэгдэл гарч ирлээ.

Цаашид зайлшгүй анхаарал татах эдгээр тулгамдсан асуудлыг эрүүл мэндийн байгууллагууд дангаараа шийдвэрлэх боломжгүй бөгөөд бусад салбар,хүн амын бүлэглэлийн төлөөлөгчид нягт хамтран ажиллаж сургууль,үйлдвэрлэл,эрчим хүч,байгаль орчин зэрэг эрүүл мэндийг дэмжигч бүхэл бүтэн сүлжээг бий болгох шаардлага тавигдаж байна.

Энэ зууны эрүүл мэндийн талаархи бодлого нь хүн амын эрүүл мэндийн үндсэн хэрэгцээг бүрэн хангах замаар бүх нийтээр эрүүл байх зорилгод чиглэх болно. Энэ нь өвчнийг анагаахад чиглэж байсан арга ажиллагаанаас хүн төвтэй,хүнийг хөгжүүлэхэд чиглэсэн арга ажиллагаа руу шилжих үйл явц болно.

Ингэхдээ хүн амыг өвчин эмгэг тусах,тахир дутуу болохоос урьдчилан сэргийлэх,эрүүл мэндэд таатай нөлөөлөх орчныг бүрдүүлэхэд нь туслах,эрүүл мэндээ хамгаалж бэхжүүлэх,эрүүл аж төрөх мэдлэг,хандлага дадалтай болгох боломж бүрдүүлэхийг гол чиглэл болгоно.

Үүнийг хэрэгжүүлэхдээ харилцан бие биеэ дэмждэг,олон салбарын болон нийгмийн бүлэглэлүүдийн хамтын ажиллагааг чухалчлан эрүүл мэндийн асуудалд хувь хүн,гэр бүл,хамт олон бүхэлдээ хүлээх үүргийг нэмэгдүүлэх нь нэн чухал гэж үзнэ.

Хүний ажиллаж, амьдарч буй гэр орон, үйлдвэр аж ахуйн газар,сургууль, соёлын байгууллага, хот суурин, зэрэг бүхий л орчин нь эрүүл мэндэд таатай нөлөө үзүүлэхүйц байх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд нь бүх шатны төрийн захиргааны хийгээд төрийн бус байгууллагатай шаардлагын хэмжээнд нягт хамтран ажиллаж чадахгүй байна.

### **3.3.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж,үйлчилгээг хангах.**

#### **Зорилт.**

Бүх нийтээр эрүүл байх зорилтыг хангах хүрээнд хүн ам, ялангуяа хөдөөгийн иргэдийн эрүүл мэндийн үндсэн хэрэгцээг хангахад шаардагдах нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулахад төрийн захиргаа, бүх нийтийн оролцоог өргөжүүлнэ.

#### **Үйл ажиллагаа.**

- ❖ Эрүүл мэндийн байгууллагуудын байршил,барилга байгууламж,эмнэлэг үйлчилгээний стандарт,хүний нөөцийн хувиарлалтыг судлан хянах үндсэн дээр эрүүл мэндийн зардлын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- ❖ Эрүүл мэндийн даатгал,хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлэх үндсэн дээр эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгож, нийгмийн салбарын хувьчлалтай уялдуулан улсын төсвийн ачааллыг багасган,санхүүжилтийн найдвартай байдлыг хангах.
- ❖ Эрүүл мэндийн төлөв байдал,хүний амьдралын чанарыг тусгасан үзүүлэлтүүдтэй болж анхан шатны нэгжийг оролцуулсан мэдээллийн сүлжээ бүрдүүлэн техникийн дэвшил,нэвтрүүлэх үндсэн дээр эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох.
- ❖ Сум багийн нийгмийн үйлчилгээний тогтолцоог хөгжүүлж сумдыг эрүүл ахуй,халдвар судлалын мэргэжлийн хяналтын нэгжтэй болгох.
- ❖ Сум багийн түвшинд эрүүл мэндийн анхны тусламжийг бүх нийтэд хүртээмжтэй,чанартай үзүүлэхэд шаардагдах түргэн тусламжийн унаа,холбооны хэрэгсэл, нэн тэргүүнд шаардлагатай чанартай эм,багаж хэрэгслэлээр хангах арга хэмжээг дэс дараатай авах.
- ❖ Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг дэмжих.
- ❖ Ядуус хөдөөгийн хүн ам,өндөр настан зэрэг өвөрмөц хэрэгцээ бүхий нийгмийн эмзэг хэсгийг эрүүл мэндийн анхан шатны тусламжинд бүрэн хамруулах,үйл ажиллагааг оролцоо санаачлагад нь тулгуурлан хэрэгжүүлэх,энэ асуудлаар тэдний мэдлэг чадавхийг дээшлүүлэх.
- ❖ Олон нийтийн хүчинд тулгуурлан тахир дутуу хүмүүст зориулсан нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх.
- ❖ Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлж тэдний мэдлэг, хандлага, дадлыг өөрчилнө.

### 3.3.2. Халдварт өвчнөөс сэргийлэх.

#### Зорилт.

- Халдварт өвчний гаралтыг 1998-2002 оны дунджаас 25 хувиар тус тус бууруулан ХДХВ/ДОХ өвчнөөс урьдчилан сэргийлж, хүүхдийг өргөн вакцинжуулалтанд бүрэн хамруулан, улаанбурханы өвчлөлийг устган,тав хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчнийг эрс бууруулна.

#### Үйл ажиллагаа.

- Амьсгалын замын цочмог халдварт болон суулгалт өвчний үед хүүхдийг гэрээр эмчлэх арга,мэргэжлийн тусламж хайх мэдлэгийг эцэг эхчүүдэд эзэмшүүлэн хүүхдийн өвчний цогц менежмент хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Хүн амын дархлалын түвшинг судалж дархлал тогтцыг сайжруулах арга зам боловсруулах.
- Дэлхийн анагаах ухааны ололт,дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж,өөрийн аймгийн өвөрмөц нөхцөл зэргийг харгалзан өргөн дархлаажуулалтыг зохион явуулах.
- ДОХ өвчинтэй тэмцэх,сэргийлэх дэд хөтөлбөрийг олон нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлэх.
- Вируст халдварыг оношлох,эмчлэх шинэ арга технологийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Халдварт өвчин үүсэхэд нөлөөлж байгаа орчны болон нийгмийн хүчин зүйлийг хянах,сөрөг нөлөөллийг арилгах,голомтыг таслан зогсоох талаар салбар хоорондын үйл ажиллагааны удирдлага зохицуулалтыг боловсронгуй болгох.

### 3.3.3. Хүн амын эмзэг хэсгийг хамгаалах.

#### Зорилт

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Хүүхэд өсвөр үеийнхнийг амьдралд бэлтгэх,идэр залуу насныханы амьдралыг хамгаалах,өндөр настны амьдралын чанарыг хангах,өсч хөгжих,эрүүл мэндээ хамгаалах таатай орчинг нь бүрдүүлж,нөөц чадавхийг нь дээшлүүлнэ.

## **Үйл ажиллагаа.**

### **а) Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар.**

- Хүүхдийг хөхөөр хооллох,хүүхдийн хоол тэжээл,иод дутлын эмгэгтэй тэмцэх,нөхөн үржихүйн эрүүл мэнд,эрүүл мэндийн боловсрол,өсвөр үеийнхэний эрүүл мэнд,дархлаажуулалт,хүүхдийн амьсгалын замын цочмог халдвар,суулгалт өвчинтэй тэмцэх асуудлаар гарсан үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.
- Хүүхдийн эрхийг хамгаалах,хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн ядуурал,орчны сөрөг нөлөөнд өртөх эрсдлийг багасгах,тэдний эрүүл мэндийн үндсэн эрэлт хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх.
- Хүүхэд,өсвөр үеийнхэн эрүүл мэндийн боловсрол,эрүүл аж төрөх ёсны зан үйл эзэмших таатай орчныг бүрдүүлж амьдралд бэлтгэх үйл ажиллагааг өөрсдийнх нь идэвхитэй оролцоотойгоор хэрэгжүүлэх.

### **б) Залуучуудын эрүүд мэндийг хамгаалах талаар:**

- Залуу гэр бүлд боловсрол эзэмших,ажил эрхлэх,нөхөн үржихүйн эрүүл мэндээ хамгаалахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх.
- Залуу үеийнхэнд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх.
- Орчны таагүй нөлөөллийг багасгах,архи,тамхи,мансууруулах бодисын дон,биеэ үнэлэх,сэтгэцийн хямралд өртөх зэрэг хорт зуршлаас өөрийгөө хамгаалахад нь дэмжлэг үзүүлэх мэдээлэл,боловсрол,зөвлөлгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож хөгжүүлэх.

### **в) Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах талаар:**

- ◆ Эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээг олон нийтэд тулгуурласан хүртээмжтэй,чанартай,урьдчилан сэргийлэх арга хэмжээнд түлхүү чиглүүлэх.
- ◆ Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг эмнэлгийн анхан шатны тусламжийн хүрээнд хүртээмжтэй,чанартай хангах боломжийг өргөтгөх.
- ◆ Уураг аминдэм,иод,төмрийн дутлаас сэргийлэхэд чиглэсэн цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх.
- ◆ Эхчүүд,нярай,нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд нэн тэргүүнд шаардлагатай,чанартай эм,багаж хэрэгслийн хангамжийг сайжруулах.
- ◆ Эмэгтэйчүүдийн эрүүл ахуй,эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх,мэдээлэл чөлөөтэй хүртэх бүх талын нөхцлийг бүрдүүлэх.

### **г) Тахир дутуу иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар:**

- Тахир дутуу болохоос урьдчилан сэргийлэх,ажиллаж амьдрах,эрүүл,аюулгүй орчин бүрдүүлэхэд аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх,хувь хүмүүс энэ талын боловсрол эзэмших бололцоог нэмэгдүүлэх.
- Тахир дутуу иргэдэд зориулсан нөхөн сэргээх эмчилгээг гэр бүл хамт олных нь дунд хийх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх.

**д) Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах талаар:**

- ❖ Хуримтлуулсан дадлага туршлагаа эрүүл мэндээ хамгаалах, амьдралынхаа чанарыг хангахад хэрэглэх боломжийг ахмад настанд олгох, гэр бүл, нийгмийн амьдралдаа идэвхитэй оролцох орчин бүрдүүлэх.
- ❖ Ахмад настанд эмчилгээ, сувилгаа хийх, асрамж, соёл ахуйн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.
- ❖ Ахмад настанг гэр бүл, ураг төрлийн хүрээ, орон нутагт нь асрамжлан халамжлах нөхцөл бүрдүүлэх.

**3.3.4. Орчны эрүүл ахуйн шаардлагыг хангах.**

**Зорилт.**

Орчны ариун цэвэр, эрүүл ахуйн хэвийн нөхцлийг хангуулах замаар хүн амын ажиллаж амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, хүн амд орчны эрүүл мэндийн талаар сургалт явуулж хүрээлэн буй орчноо хамгаалах талаар мэдлэг олгоно.

**Үйл ажиллагаа.**

- Байгаль орчны бохирдолтонд үнэлгээ хийлгэж гадаад орчны бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах.
- Орон сууцны оршин суугчдын хог хаягдлыг ангилан хадгалах уутаар хангаж нэгдсэн журмаар тээвэрлэдэг болох, хог хаягдлыг дахин боловсруулах жижиг оврын үйлдвэртэй болох.
- Төв суурин газрын хогийг байгаль орчинд халгүйгээр дарж устган хөрсийг эрүүлжүүлэх арга хэмжээ зохион байгуулах.
- Хогийн нэгдсэн цэгийг ариун цэвэр эрүүл ахуйн стандартад нийцүүлэн тохижуулах.
- Бохир усыг цэвэрлэх байгууламж барьж ашиглалтанд оруулах, хог хаягдал зайлуулах хүн хүч техник хэрэгслийн хангамжийг сайжруулах.
- Аймгийн төвийн төвлөрсөн ус хангамжийн 2,5 км шугам хоолойг зориулалтын ган хоолойгоор солих.
- Хүн амыг УСТ-900-92-н шаардлагад нийцсэн ундны усаар хангах үүднээс ундны усыг төмөргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах, халдваргүйжүүлэх, хлоржуулах.
- Албан байгууллага, аж ахуйн нэгжийн эзэмшил газар, нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэцэрлэгжүүлэх ажилд албан байгууллага, иргэдийг татан оролцуулж урамшууллын системийг бий болгох.
- Нутагшмал өвчний тархацад нөлөөлөх хүчин зүйлийн талаар судалгаа явуулж үнэлгээ өгөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.
- Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хүнс хоолны гаралтай сөрөг нөлөөлөлийг хянах шалгах, урьдчилан сэргийлэх замаар хүнсний аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх.
- Лабораторийг бэхжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, боловсон хүчнийг мэргэшүүлэх.
- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж ажлын байрны стандарт мөрдүүлэх.
- Ажлын нөхцлийг сайжруулах, ажилчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн сургалт зохион байгуулах замаар үйлдвэрийн ослыг бууруулах.
- Иргэдэд байгаль орчинтой холбоотой хууль тогтоомжуудыг сурталчлах, ЕБС-ийн сурагчдад орчны эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулж энэ талын мэдлэг олгох.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- Орчны хяналт үнэлгээ, судалгааны чиглэлээр ерөнхий болон нарийн мэргэжлийн хүмүүсийг сургаж мэргэжилтэн бэлтгэх.

### **3.4 Хүн амын боловсролыг дээшлүүлэх**

#### **Үндэслэл**

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 5 сургуульд 2934 сурагч суралцаж, сургуулийн өмнөх насны 1277 хүүхдээс 530 буюу 41,5 % нь сургуулийн өмнөх байгууллагад хамрагдаж байна. Ерөнхий боловсролын сургуульд анги дүүргэлт 31,5, 1 багшид ноогдох сурагчийн тоо 23,4 хамран сургалт 89 %-тай байна. Аймгийн хэмжээнд 10 түүнээс дээш насны хүмүүсийн 88,4% ямар нэг түвшний боловсрол эзэмшсэн, 11,6 хувь нь боловсролгүй байна.

Мэргэжлийн багшийн хангамж 86%-тай бөгөөд математик, физик, бага анги, техник хөдөлмөр, цэцэрлэгийн багш зэрэг гол мэргэжлийн багш дутагдалтай, магистр түүнээс дээш зэрэгтэй багш нар харьцангй цөөн байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн барилга, байгууламжид сүүлийн жилүүдэд бодитой засвар хийгдээгүй, сургуулиудын 80 хувь нь орос цэргийн ангийн ажилчдын хүүхдийн суралцаж байсан сургуульд засвар хийж ашиглаж байгаа боловч анги танхимын багтаамж муу, халаалтын шугам шаардлага хангахгүй, сургалтын техник хэрэгсэл, сургачийн ширээ сандал дутагдалтай байна.

#### **Зорилт**

Мэргэшсэн чадварлаг хөрвөх чадвартай багш удирдах ажилтнаар бүрэн хангаж, хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх замаар хүнийг бүх талаар хөгжүүлж, сургалтын орчин үр дүнг дээшлүүлэх менежментийг боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

#### **Үйл ажиллагаа**

- Мэргэжилтэй багшаар хангаж, багшийн хөгжлийг дэмжиж сургалтын чанарыг дээшлүүлнэ.
- Бүх нийтийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгана.
- Нийгмийн эмзэг бүлгийн орлого багатай айл өрхийн хүүхдийн боловсрол эзэмшихэд нь тусламж, дэмжлэг үзүүлж, сургууль завсардалтыг бууруулж хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- Сургалтын хэрэглэгдэхүүн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, орчны стандартыг сайжруулж, сургууль цэцэрлэгийн барилгад их засвар хийж, боловсролын байгууллагын материаллаг бааз нөхцлийг сайжруулна.
- Аж ахуйн нэгж байгууллага иргэдийн өмчид суурилсан төрийн өмчийн бус боловсролын байгууллага, МСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжинэ.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх орон нутгийн тогтолцоо бий болгоно.
- Сургууль багш нарын ажлыг үнэлэх арга зүйг боловсронгуй болгоно.
- Боловсролыг хөгжүүлэх үйл хэрэгт, төр олон нийтийн болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний хувь нэмрийг хөхүүлэн дэмжинэ.
- Боловсролын салбарт ажиллагсад, суралцагсадын хүйсийн ялгааг арилгах
- Бүх нийтийн боловсрол, мэргэжлийн тасралтгүй чанарыг хангахын тулд албан бус боловсрол, зайны сургалтын тогтолцоог бүрдүүлж, санхүү, материалын тусалцаа үзүүлэх энэ ажилд бүх нийтийн нөөц бололцоог өргөн ашиглах

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- Боловсролын байгууллагуудын зарим бололцоотой барилга, байгууламж, техник тоног төхөөрөмжийг зориулалтаар нь түрээслүүлэх, аж ахуйн нэгж байгууллагатай хоршиж ажиллуулах чиглэлийг дэмжих
- Боловсролын байгууллагыг менежментийн хувьчлалд хамруулах

### **3.5 Соёл урлагийг хөгжүүлэх**

#### **Үндэслэл**

- Мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааны материаллаг бааз бэхжээгүй
- мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай
- Мэргэжлийн байгууллагын болон соёлын бодлогын менежмент хангалтгүй
- Иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмж муу, байнгын бус үйл ажиллагаа явуулдаг
- Соёлын байгууллагууд чиг үүргээ биелүүлэхэд нэн шаардлагатай стандартын барилга байгууламж байхгүй байна.

#### **Зорилт**

- Нутгийн уламжлалт соёлыг хамгаалах, залуу үед өвлүүлэх, мэргэжлийн урлаг, соёлын байгууллагуудыг сэргээн бэхжүүлж иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

#### **Үйл ажиллагаа**

- Орон нутагт байгаа утга соёлын өв, түүх соёлын дурсгалт зүйлс, ардын урлаг, оюуны соёлын үнэт өвийг орон нутгийн хамгаалалтад авч сурвалжлан олж, сурталчлах.
- Утга соёлын өвийн дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийн сан байгуулах
- Оюуны үйлдвэрлэлийн цар хүрээг өргөтгөж, материаллаг баазыг бэхжүүлж, мэдээллийн сүлжээг бий болгох.
- Дизайны урлагийг хөгжүүлэх
- Оюуны сэтгэлгээний хөгжилд түлхэц өгөхүйц, уран сайхны өндөр түвшинд бүтээсэн урлагийн бүтээлийг дэмжих
- Мэргэжлийн урлагийн байгууллагын урын санг баяжуулж, тэдгээрийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, ажиллагсадын нийгмийн баталгаа, ажиллаж амьдрах нөхцлийг нь дээшлүүлэх
- Ардын уламжлалт урлагийн өв санг судлан бүтээлчээр суралцах замаар чуулга, соёлын төвийн уран бүтээлийн чанар, уран бүтээлч, багшийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах
- Музейн үзмэр, номын сангийн фондыг баяжуулж, үйлчилгээг сайжруулах
- Иргэд хүүхэд залуучуудын амьдрал ахуй биеэ авч явах байдлыг нь соёлжуулах, харилцааны соёлыг сайжруулах ажлыг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах
- Хүний шүтэн бишрэх эрх чөлөөг тууштай хангана.

### **3.6 Хүн амын суурьшил нутагшил**

#### **Үндэслэл**

Эдийн засгийн дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, бизнесийн таатай орчинтой, амьжиргааны өртөг хямд зэрэг давуу талд татагдсан зэргэлдээ аймгийн иргэдийн шилжилт, суурьшилтын төв нь Говьсүмбэр болж хүн амын механик өсөлт цаашид тасралтгүй үргэлжлэх төлөвтэй. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд тус аймагт улсын

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот чанартай томоохон үйлдвэрүүдийг барьж байгуулах явдал хүн амын хэтийн өсөлтөд чухал нөлөө үзүүлэх бөгөөд энэ нь бас аймагт ойрхон оршдог нийслэлийн хүн амын нягтралыг багасгах ач холбогдолтой, аймгийн орон сууцны нөөцийг бүрэн ашиглахад тус дөхөм болно.

## **Зорилт**

Хүн амын хэрэгцээг хангахад чиглэсэн нийгмийн дэд бүтцийг түлхүү хөгжүүлж, хүн амын зохистой өсөлт, иргэдийн амьжиргааны түвшинг хангах эдийн засгийн нөөц бүрдүүлэх

## **Үйл ажиллагаа**

- Хүн амын биологийн болон механик өсөлтийг тэнцвэртэй байлгаж, төвлөрсөн хот, говийн бүсийн аймгуудаас иргэд шилжин суурьшихад шаардлагатай нийгмийн дэд бүтэц, үйлчилгээний нөхцөл бүрдүүлнэ.
- Малчдыг сэргээгдэх эрчим хүч, техник хэрэгслээр хангах замаар суурин газрын төвлөрлийг сааруулж, малчдыг мэдээллээр тогтмол хангах нөхцөл бүрдүүлэх
- Экологийн тэнцвэр, цэвэр байдлыг хангах шаардлагыг үндэс болгон хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн хувийн орон сууц барих хөдөлгөөн үүсгэл, санаачлагыг дэмжин, нийт иргэдийн 80-аас доошгүй хувийг тохилог орон сууцаар хангах
- Аймаг, суманд ахуйн үйлчилгээний төвтэй болох

## ***ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ***

### **4.1 ХАА-н тогтвортой хөгжил**

#### **Үндэслэл**

Аймгийн хэмжээнд 3330 ам бүл буюу 808 малчин өрх байгаа нь аймгийн нийт өрхийн 25.1 хувь, хүн амын 25.6 хувийг эзэлж байна.

Аймгийн нийт 80044 толгой малын 5679 буюу 7 хувь нь албаны, 74365 буюу 93 хувь нь амины мал гэж бүртгэгдсэн байна. Үүнээс үзэхэд нэг малчин өрхөд дунджаар 92-99 толгой мал, нийт хүн амын нэг хүнд 5-6 толгой мал оногдож байгаа нь өмнөх жилийнхээс 8 хувиар өссөн ч 1999 оныхоос 50 хувиар буурсан байна.

Нийт малчин өрхийн 727 буюу 89.9 хувь нь 200 хүртэл малтай, үүнээс 57 хувь нь 100 хүртэл малтай, нийт малчин өрхийн дөнгөж 10.1 хувь нь буюу 81 нь 1500 хүртэл малтай байна.

Гэвч малын нэгжээс авах ашиг шим бага, байгалиас хараат байдал нь хэвээр байна.

Мал тооны хувьд өмнөх жилийнхээс өссөн ч сүргийн бүтэц, чанарын хувьд ахиц гараагүй. Хээлтэгч малын сүрэгт эзлэх хувь нь 43.3. Мах болон сүү үйлдвэрлэл тогтвортой бус. МАА-н гаралтай түүхий эд боловсруулах цэх, жижиг дунд үйлдвэр байхгүй байна.

Сүүлийн жилүүдэд өрхийн болон усалгаатай тариалалт өргөжиж, тариалан жилд дунджаар 12-17 тн төмс, хүнсний ногоо хураан авч байна.

ХАА-н үйлдвэрлэлд жил дараалсан ган, зуд, зэргэлдээ аймаг сумдын оторчдын малын хэт бөөгнөрөл, малын гоц халдварт олон улсын “А” ангиллын А-010 өвчин зэрэг сөрөг нөлөө бүхий үр дагавруудыг багасгах, арилгах, даатгалын тогтолцоог бий болгох, хүнсний бүтээгдэхүүний ариун цэвэр эрүүл ахуй, чанарын шаардлагыг хангах, аюулгүй байдлыг баталгаажуулах шаардлага тулгамдаж байна.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний чанар, хариуцлага үлэмж суларсан, малд урьдчилан сэргийлэх тарилга, туулга, угаалгыг нэр төдий хийснээр хязгаарлагддаг, халдварт, паразиттах өвчний шинж тэмдэг бүхий мал сүргийн шилжилт хөдөлгөөн хяналтгүй болсон, аймгийн хэмжээнд халдварт өвчний гаралт тайван хэдий ч зэргэлдээ аймаг сумдад устсан гэгдэж байсан халдварт өвчнүүд удаа дараалан гарсан.

Малчид хэрэгцээнээсээ илүү бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадваргүй, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоо бүрэлдээгүй, түүхий эдээ чанартай бэлтгэж, борлуулах зах зээлийг зөв сонгох мэдлэг, чадавхи сул, ХАА-н салбарын бүтцийн зохион байгуулалт, хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй зэрэг нь энэ салбарын үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах, эдийн засгийн болон нийгмийн үр ашгийг дээшлүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөтэй байна.

#### **4.1.1 Хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах**

##### **Зорилт**

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлэх, нутгийн малын чанарыг сайжруулах, каракуль хонины удмын санг хамгаалах, хадгалах, хөрсний үржил шимийг хамгаалах, байгаль орчинд халгүй технологиор газар тариалан эрхлэх, нэг малаас, нэгж талбайгаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, ХАА-н гаралтай хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

##### **Үйл ажиллагаа**

- ❖ Малын удмын санг хамгаалах, үржлийн бодлогыг боловсронгуй болгох, үржлийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх
- ❖ Аймгийн ХАА-н бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулан, хэрэгжүүлэх
- ❖ Каракуль хурганы арьс болон бусад арьс нэхийнд анхан шатны боловсруулалт хийдэг цех, жижиг үйлдвэр хөгжүүлэх
- ❖ Каракуль хурганы нядалгааны цехийг сэргээн засварлаж, түүнээс гарах ходоод, цүрд, нарийн гэдэс, мах, яс, цусыг ашиглах, боловсруулат хийх жижиг үйлдвэр хөгжүүлэх
- ❖ Өрхийн болон хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, төмс хүнсний ногоо тариалах ажлыг эрчимжүүлэх, усалгаатай газар тариаланг хөгжүүлэх
- ❖ “Сүмбэр” хонины тоо толгойг тогтвортой өсгөх, удмын санг хамгаалах
- ❖ Гахай, шувуу болон бусад туслах аж ахуйг хөгжүүлэх, хагас болон суурин маллагаатай эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх
- ❖ Бэлчээрийн мал маллагаа, эмчилгээний уламжлалт арга технологийг баяжуулан хөгжүүлэх
- ❖ Аюулгүйн нөөцийн зориулалт бүхий гол нэрийн барааны орон нутгийн нөөцийн сан бүрдүүлэх, нөхөн сэлбэх
- ❖ Хүнсний бүтээгдэхүүнээр дотоод зах зээлээ хангахын зэрэгцээ экологийн цэвэр бүтээгдэхүүнээр бүсийн хэмжээнд тодорхой байр суурь эзлэх
- ❖ Мал нядалгааны болон мах боловсруулах анхан шатны байр, зориулалт бүхий газартай болох, мах бэлтгэлийг нэмэгдүүлэх
- ❖ Тэжээлийн ургамал тариалах



#### **4.1.2 Хөдөө аж ахуйд тохиолдох эрсдлийг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах**

##### **Зорилт**

Байгалийн гамшиг, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ, зохион байгуулалтыг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах

##### **Үйл ажиллагаа**

- Бэлчээрийн даацыг жил бүр тодорхойлон, түүндээ тохируулан бэлчээрийг хуваарьтай ашиглах, аймаг, сум дундын отрын болон нөөц нутгийг орон нутгийн мэдэлд байлгах
- Өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг аймаг, сумд, албан байгууллага, аж ахуйн нэгж зэрэг бүх шатанд бүрдүүлэх.
- Малын халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж хэвших, энэ чиглэлд малчдын хариуцлагыг дээшлүүлэх
- Хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг эдийн засаг, зохион байгуулалтын талаар бэхжүүлэхэд гадаад, дотоодын зээл, тусламж, төслийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, хүлээх хариуцлагыг нь өндөржүүлэх
- Аймгийн ХХААГ болон МХГ-ын мал эмнэлгийн хяналтын дор ажиллах мал эмнэлгийн ариун цэврийн болон оношлох лабораторийг байгуулахад гадаад, дотоодын зээл, тусламж, хөрөнгө оруулалтыг ашиглах, хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих.
- Хүнсний бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд найдвартай хадгалах агуулахын аж ахуйг хөгжүүлэх
- Хүнсний нөөц бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдаалах хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг баталгаажуулж, түүнд тавих хяналтыг боловсронгуй болгох
- Хүн амын махны хэрэглээний бүтцэд гахай, тахиа, загасны мах оруулж өөрчлөх, цөцгийн тосны хэрэглээг шар, цагаан тос, өрөм, цөцгий зэргээр орлуулах боломжийг бүрдүүлэхэд бодлогоор дэмжлэг үзүүлэх

#### **4.1.3. Хөдөө аж ахуйн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, зах зээлийн эдийн засгийн орчин бүрдүүлэх**

##### **Зорилт:**

ХАА-н салбарын менежмент, маркетингийн удирдлагыг боловсронгуй болгох, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт шалгалт, хариуцлага, сургалтын тогтолцоог бүрдүүлэх

##### **Үйл ажиллагаа**

- ❖ Аймаг, сум, Мал эмнэлэг үржлийн нэгжүүдийн түвшинд ХАА-н салбарын хөгжлийн дунд болон богино хугацааны иж бүрэн төлөвлөгөө боловсруулан, тэдгээрийн хоорондын уялдааг ханган хэрэгжүүлэх
- ❖ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, үйлдвэрлэгчдээс техник технологи болон үйлдвэрлэл аж ахуйгаа үр ашигтай эрхлэн хөтлөхөд нь дөхөм болохуйц эрдэм шинжилгээ, сургалтын тогтолцоог бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- ❖ Малын үржил селекцийн ажлын шаардлагад нийцүүлэн малаа сонгон үржүүлэх сонирхлыг төрүүлэх, зах зээлийн үеийн аж ахуйг зохион байгуулах, бүтээгдэхүүн, түүхий эдээ боловсруулах, мөнгө санхүүгийн нөөцөө аривжуулах, үр дүнтэй зарцуулах арга ухаанд суралцуулах, үйлдвэр, малчид хоорондын тогтвортой хамтын ажиллагааг хөгжүүлэх
- ❖ Малчид, тариаланчид, ХАА-н мэргэжилтнүүдэд өвс тэжээл бэлтгэх, тээвэрлэх, хашаа хороо барих, бэлчээр усжуулах, сайжруулах, түүхий эд боловсруулах, борлуулах, мал аж ахуйн тоног төхөөрөмж үйлдвэрлэх, хүнсний ногоо, болон тэжээлийн ургамал тариалах, мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхэлэх зэргээр хорших, жижиг, дунд үйлдвэр байгуулан ажиллах хэлбэрийг дэмжих
- ❖ Малчдаас түүхий эдийг шат дамжлага багатайгаар худалдан авч, өргөн хэрэглээний барааг шуурхай нийлүүлэх бөөний болон жижиглэн худалдаалах тогтвортой сүлжээг бий болгох.
- ❖ Мал аж ахуйн түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх% нийлүүлэх үйл ажиллагааг хослох.
- ❖ Газар тариалангийн салбарт хөрөнгө оруулалтыг татаж үр ашигтай өмчийн олон хэлбэрийн аж ахуйг хөгжүүлэх.
- ❖ Газар тариалангийн фермерийн болон хоршоололын хэлбэрийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, санхүүгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх.
- ❖ Газар тариалангийн бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалтад зуучлах аж ахуйн дундын болон бие даасан аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулж ажиллуулахыг дэмжих.
- ❖ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хоршоололыг боловсронгуй болгох, бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх.
- ❖ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийн удирдлагыг боловсронгуй болгох, менежмент маркетингийн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах.
- ❖ Хот айл, аж ахуйн нэгжтэй зах зээлийн мэдээлэл солилцох, бэлтгэсэн түүхий эдийг найдвартай зах зээлд худалдах нөхцөлийг бүрдүүлэх.
- ❖ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг цаг тухайд нь шинэ техник, технологи, зах зээлийн болон үнийн мэдээлэлээр хангах, зохион байгуулалтын бүтцийг бий болгох.

## 4.2 Аж үйлдвэр, дэд бүтцийн тогтвортой хөгжил.

### Үндэслэл

Аймгийн нутаг дэвсгэрт Шивээ-Овоогийн нүүрсний ил уурхай, Геологи хайгуулын Говь-гео хувьцаат компани, цахилгаан шугам сүлжээний дэд станц, нефть бааз зэрэг томоохон аж ахуйн байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Тус аймгийн нутгаар өнгөрч байгаа Сүхбаатар-замын Үүдийн төмөр замын тээх, нэвтрүүлэх хоногийн чадвар нь Улаанбаатар-Чойрын хооронд 16 хос, Чойр-Замын үүдийн хооронд 7 хос цуваа юм. Тус аймаг дахь нефть хангамжийн авто тээврийн хэрэгслээр шатахуун, тосолгооны материалыг говийн аймгуудад тээвэрлэн хүргэдэг. Холбооны салбар нь 324 суваг бүхий телевизийн релейний шугамтай, телефоны утсан холбооны 2-3 сувгаар үйлчилгээ үзүүлдэг. Аймгийн нутагт чулуун нүүрч, газрын ховор элементийн илрэл нөөцтэйн гадна хүнд даацын онгоц буух нисэх буудал Баянтал суманд бий.

Бүх сумын төв эрчим хүчний байнгын, хүрэлцээтэй эх үүсвэртэй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын жигд ажиллагааг хангах боломжтой. Аймагт инженерийн хийцтэй 25 зуух ажиллан, төв суурин газрын хэрэгцээнд зориулан дулааны эрчим хүч түгээдэг. Жилд дунджаар нэг хүнд 216 квт цахилгаан эрчим хүч ногдож буй нь хэрэглээ доогуур байгааг харуулна.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот  
Цахилгаан, дулааны эрчим хүчний алдагдал нэлээд гарч байгаагаас гадна, хэрэглэгчдийн өрийн сүлжээ өргөжсөн байна.

Говьсүмбэр аймагт өнөөгийн байдлаар 3192 айлын орон сууц, 3 зочид буудал, 500 хүний суудалтай 3 клуб болон худалдаа соёл, ахуйн үйлчилгээний зориулалттай олон барилга байгууламж бий. Эдгээрээс олон тооны угсармал орон сууц ашиглалтгүй байна.

#### **4.2.1 Аж үйлдвэр, тээвэр холбоо**

##### **Зорилт**

Байгалийн хүчин зүйл, нөөцөд тулгуурлан хүн ам өөрийгөө бүрэн тэтгэх эдийн засаг, нийгмийн хөгжлийн оновчтой, шинэ бүтцийг бий болгож, аж үйлдвэрийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх

##### **Үйл ажиллагаа**

- Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн тоног төхөөрөмжийг шинэчлэх, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалд геологийн бүрэн хайгуул, судалгаа хийх, олон улсын жишигт нийцсэн төсөл бэлтгэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах.
- Уул уурхайн болон техникийн мэргэжилтэн бэлтгэх асуудлыг орон нутагтаа бэлтгэх боломжийг судлан хэрэгжүүлнэ.
- Дэд бүтцийн эерэг талд түшиглэн үйлдвэрлэл үйлчилгээг үр ашигтайгаар өргөтгөх, ажлын байр бий болгох дэс дараатай арга хэмжээ авах
- Аймаг, сумын төв, малчид, тариаланчдад шуурхай үйлчлэх холбоо, мэдээллийн орчин үеийн тогтолцоо бий болгох.
- Эрдсийн түүхий эдийн нөөц ашиглан дор дурьдсан үйлдвэрийг барьж байгуулах:
  - зам барилгын материалын үйлдвэр
  - барилгын шил, дулаалгын материалын үйлдвэр
  - бал чулууны үйлдвэр
  - нүүрсний химийн үйлдвэр
  - эрдэс будгийн үйлдвэр
  - ханын материалын үйлдвэр
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан байгуулах
- Хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг хангах зорилгоор хүнсний жижиг, дунд үйлдвэрийг байгуулна.
- Аймгийн төвд 500 метр хатуу хучилттай зам барих
- Тэрэгт-Чойрын цэвэр ус дамжуулах 2,5 км шугамыг сольж сайжруулах
- Халаалтын зуухны үр ашиг, чанарыг сайжруулан техник технологийн шинэчлэл хийнэ.

#### **4.2.2 Эрчим хүч**

##### **Зорилт**

Хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай хангах, хэрэглээнд хяналт тавих.

##### **Үйл ажиллагаа**

- ❖ Эрчим хүчний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр бий болгох

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- ❖ Аймаг, сумын төвийн дулааны зуухны техникийн өөрчлөлт хийх, шугамыг шинэчлэх
- ❖ Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн нөхцөл сайжруулах асуудлыг бүрэн шийдвэрлэх
- ❖ Цахилгаан дулааны зарцуулалтыг бүрэн тоолууржуулах
- ❖ Сэргээгдэх эрчим хүчний техник хэрэгслийг ялангуяа малчин өрх, хот айлд хэрэглэх явдлыг тэргүүн ээлжинд дэмжин урамшуулах
- ❖ Цэвэр усны байгууламжийн найдвартай ажиллагааг хангах
- ❖ Баянтал, Шивээговь сумын төвийг цэвэрлэх байгууламжтай болгох

#### 4.2.3 Барилга, орон сууцны хангамж

##### Зорилт

Ашиглалтгүй байгаа орон сууцны болон бусад барилга байгууламжийг сэргээн засварлаж ашиглах. Иргэдийн орон сууцны нөхцлийг сайжруулах, нийгмийн үйлчилгээ явуулах барилга байгууламжид зарцуулах хөрөнгө оруулалтыг чиглүүлэх .

##### Үйл ажиллагаа

- ❖ Ашиглалтгүй угсармал орон сууцнуудыг сэргээн засварлаж ашиглах;
- ❖ Хувийн орон сууц барих, хямд төсөр барилгын материалаар хангах ажлыг зээлийн бодлогоор дэмжих;
- ❖ Тоногдож нурсан барилга байгууламжийн үлдэц, хаягдлыг ашиглан ханын блок үйлдвэрлэх;

### ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН ТҮҮНИЙ НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ

#### 5.1. Агаар мандлыг хамгаалах

##### Үндэслэл

Аймгийн хэмжээгээр нийт 22 уурын зуух ажиллаж, жилдээ 21640 тн нүүрс, ердийн галлагаатай 700 гаруй айл өрх өвлийн цагт 3500-4000 тн нүүрс хэрэглэсний утаа, 800 гаруй автомашин, өөрөө явагч хэрэгслээс ялгарах утаа, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн тоосжилт, зэрэг нь агаар мандлыг бохирдуулах гол эх үүсвэр болж байна.

Аймгийн ус цаг уурын албанд агаарын бохирдлыг хэмжих багаж, тоног төхөөрөмж байхгүйгээс агаарын бохирдлын хэмжээг нарийн тодорхойлж чадахгүй байна.

##### Зорилт

Агаарын бохирдлыг хэмжих тоног төхөөрөмжтэй болох, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог багасгах, хүн амьтан байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тооцож арилгах, байгаль орчинд халгүй арга технологийг шинээр нэвтрүүлэх

##### Үйл ажиллагаа

- ❖ Ус цаг уурын албыг агаарын бохирдлыг хэмжих багаж тоног төхөөрөмжтэй болгох
- ❖ Ус цаг уурын ажиглалтын цэгийг Сүмбэр сумын Малхын багт шинээр байгуулах.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хог

- ❖ Төвлөрсөн уурын зуух болон бусад объектуудад байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэж, байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллуулж, тогтмол хяналт тавьж байх
- ❖ Айл өрхийн ердийн галлагаат зуухыг түлш бага зарцуулдаг утаагүй зуухаар шинэчлэх ажлыг эрчимжүүлэх, уг зуухыг ард иргэдэд сурталчлах.
- ❖ Хог хөтөлбөрийн хүрээнд хуурай хог хаягдлыг ялган боловсруулдаг бага оврын хог боловсруулах үйлдвэр байгуулах.
- ❖ Бүх төрлийн тээврийн хэрэгслийг техник оношлогооны төвөөр дамжуулан хэмжилт хийж агаар ихээр бохирдуулж буй тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулахгүй байх.
- ❖ Төв суурин газарт ногоон байгууламжийг бий болгох, энэ ажилд ард иргэдийг оролцуулан бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

## **5.2. Газар, газрын хэвлийг зохистой ашиглах хамгаалах**

### **Үндэслэл**

Төв суурин газарт авто тээврийн хэрэгсэл олширсноос олон салаа зам бий болсон, ахуйн хог хаягдал ихсэж, талбайн хэмжээ нэмэгдсэн, ухагдаж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэх үйл ажиллагаа хийгдээгүй зэргээс болж төв суурин газрын хөрс маш ихээр эвдрэлд орсон.

Нийт бэлчээр ашиглалт нь жигд бус, ургамлын нөмрөг удаан хадгалагддаг нутагт мал хэт олноор бөөгнөрснөөс ургамлын хэнзлэлт, нөхөн ургалт байхгүй болж бэлчээр сэргэх нөхцөлгүй болсон байна. Сүүлийн жилүүдэд аймгийн бэлчээрийн даац, бэлчээрт тархсан хортон мэрэгчдийн судалгаа гарган уламжлалт болон хор цацах аргаар устгах ажлыг хийж эхлээд байна.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхай олборлолт явуулж байгаа ч зөвхөн технологийн нөхөн сэргээлт хийж, биологийн нөхөн сэргээлт буюу хөрсийг ургамалжуулах ажлыг хийгээгүй байна. Мөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг стандартын дагуу боловсруулаагүй ажиллаж байна.

Налайх-Чойрын хатуу хучилттай замын ажилд өнгөрсөн онд элс хайрганы 8 карьер ашигласнаас 5-г нь нөхөн сэргээсэн байна.

Аймгийн төвд цэвэрлэх байгууламж байхгүйгээс бохир усыг цэвэрлэлгүйгээр зайлуулснаар хотын төвд бохирын хиймэл нуур бий болон талбайн хэмжээ нэмэгдэж байна.

### **Зорилт**

Газрыг элэгдэл эвдрэлээс хамгаалах, цөлжилтийг сааруулах эвдэрсэн газрын нөхөн сэргээх ажлыг тогтмолжуулж, газрын хэвлийн ашиглалтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газрыг өмчлүүлэх эзэмшүүлэх, ашиглуулах харилцааг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх.

### **Үйл ажиллагаа**

- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй болох
- Иргэн аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудлыг газар зохион байгуулалтын болон хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх
- Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмшил ашиглалтын байдалд хяналт тавьж, газрыг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах, газар эзэмшигч, ашиглагч

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

бүр ногоон байгууламж бий болгох, хөрсийг хамгаалах арга хэмжээг заавал авч хэрэгжүүлэх.

- Газрын төлбөр, ашигт малтмалын орд ашигласны төлбөрийн тодорхой хэсгийг газрыг заавал нөхөн сэргээх, хамгаалах, ногоон байгууламжийг өргөтгөх, мод бут тариалах цөлжилтөөс сэргийлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулна.
- Ашигт малтмал олборлох болон хайгуулын үйл ажиллагаа явуулсан үед газрыг нөхөн сэргээх, хөрсжүүлэх, ургамалжуулах үйл ажиллагааг тухай бүрд нь хэрэгжүүлж хэвших
- Аймгийн нутаг дэвсгэрт илэрсэн ашигт малтмалуудын нөөцийг нарийвчлан тогтоож байгаль орчинд халгүй арга технологээр ашиглах, байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллуулах,
- Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын лиценз эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгож энэ арга хэмжээнд шаардагдах зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг аймаг, сумын тусгай дансанд төвлөрүүлэн зарцуулна.
- Барилга хот байгуулалт, засмал замын ажилд шаардлагатай карьерийг олгож, ашиглаж дууссан карьерийн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх.
- Ашигт малтмалын олборлох болон хайгуулын үйл ажиллагаа явуулсан үед газрыг нөхөн сэргээх, хөрсжүүлэх, ургамалжуулах үйл ажиллагааг тухай бүрд хийлгэж хэвших.
- Бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байх, хортон мэрэгчдээс хамгаалах, байгаль орчинд халгүй аргаар устгах, бэлчээрийг хуваарьтай ашиглах аргад иргэдийг сургах
- Бэлчээрт олон наст ургамал тариалах, ойжуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.
- Орон нутгийн хамгаалалттай газарт байгаль хамгаалагч ажиллуулах, ховор амьтан ургамлыг өсгөн үржүүлэх төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газруудыг хамгаалалтанд авч аялал жуулчлалыг хөгжүүлэх, сэргээн засварлах

### 5.3. Цөлжилтөөс сэргийлэх

#### Үндэслэл

Төв суурин газарт ногоон байгууламж бараг байхгүй, бэлчээрт царцаа, үлийн цагаан оготно зэрэг амьтад тархаж, хүний буруу үйл ажиллагааны улмаас газрын хөрс эвдрэлд орсон зэргээс болж шороон шуургатай байх өдрийн тоо нэмэгдэж, элсний нүүлт ихсэн цөлжилт эрчимтэй явагдаж байна.

#### Зорилт

- Элсний нүүлтийг зогсоох зорилгоор ногоон байгууламжийг бий болгох, ойн зурвас байгуулах, цөлжилтийн зэрэглэл тогтоох судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, цөлжилттэй тэмцэх хөтөлбөр боловсруулж ажиллах
- Хөрсний эвдрэлийг багасгах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх

#### Үйл ажиллагаа

- ❖ Цөлжилтийн зэрэглэлээ тогтоолгож, цөлжилтийн талын мэдээллийн сантай болох.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- ❖ Цөлжилт үүсэн бий болж буй шалтгаан нөхцлийг судалж тийм газруудад хамгаалалтын зурвас бий болгон говь хээрийн нөхцөлд тохирсон мод бут сөөгийг тариалах.
- ❖ Ухагдаж эвдэрсэн газар, нүх шуудууг тэгшилж, хөрсжүүлэх, ойн зурвас байгуулах
- ❖ Ганд тэсвэртэй говь хээрийн нөхцөлд зохицсон ургамлыг тариалах
- ❖ Суурин газрын болон хөдөөгийн замын сүлжээтэй болж, тэмдэгжүүлэх.

#### **5.4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах**

##### **Үндэслэл**

Ан амьтны хувьд 4 баг, 11 овог, 20 төрөлд хамрагдах амьтан тархсан. 4 төрлийн туурайтан, 7 төрлийн махчин, 5 зүйл мэрэгч, 8 төрлийн жигүүртэн, хэвлээр явагч амьтан, шавьжтай.

Тус аймгийн Чойрын богд, Сансар уулын орчимд 100 гаруй аргаль, 10 гаруй янгир нүүдэллэн амьдарч, Халзангийн говь, Хүрэн дух, Баянхошууны говь, Нүхэн сондуул, Тогоогийн булаг орчимд хар сүүлт, цагаан зээр нутагшиж 2000 оны судалгаагаар 6000 гаруй байна гэсэн тооцоо гарсан. Хээрийн тарвага нэг га-д 42 коэффициент байгаа нь улсын дундаж хэмжээнд байна.

Жигүүртэн шувуудаас талын бүргэд, элээ, харцага, сар, ууль, ховордсон шувуудаас цармын бүргэд, идлэг шонхор зэрэг шувууд уул, хад асга бүхий газар үүр засан амьдардаг.

##### **Зорилт**

Биологийн төрөл зүйлийг зохистой ашиглах, ховордож цөөрч буй ургамал амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх замаар экологийн тэнцвэрт байдлыг хангана.

##### **Үйл ажиллагаа**

- Аймгийн ангийн нөөцийг тогтоолгох, биологийн төрөл зүйлийн нөөц, тархалт, нутагшилтын мэдээллийн сан бүрдүүлэх
- биологийн төрөл зүйлийг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Зөвшөөрөлгүйгээр ан амьтан агнах, барих, байгалийн ургамал ашиглах зэрэгт тавих хяналтыг чангатгах.
- ховордсон болон устаж болзошгүй амьтан ургамлыг хамгаалахад биотехникийн арга хэрэглэх.

#### **5.5. Усны нөөцийг ашиглах, хамгаалах**

##### **Үндэслэл**

Говь хээрийн бүсэд оршдог гадаргын усны сүлжээгүй учраас усны бүх хэрэглээг газар доорхи усаар хангадаг бөгөөд энэ ус нь эрдэсжил хатуулаг ихтэй, ашиглахад тэр бүр тохиромжгүй байдаг.

Суурин газрын усан хангамжийн хувьд үйлдвэрлэлийн лабораторигүй, цэвэр усан хангамжийн шугам хоолой хуучирч муудсан, усан дахь төмрийн агууламж хэт их байдаг зэргээс болж чанарын баталгаагүй ундны усыг хэрэглэж байна.

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Гэр хороололд амьдарч буй хүнд хоногт дунджаар 8-9 л ус ногдож байгаа нь эрүүл ахуйн шаардлагаас даруй 4-5 дахин бага байна.

Бэлчээрийн усан хангамжийн хувьд авч үзвэл өрөмдмөл, богино яндант, энгийн, бетонон хашлагатай худаг 246 байгаагаас Сүмбэр суманд 197, Баянтал суманд 15, Шивээговь суманд 34 байна. Бэлчээрийн усан хангамжийн хувьд үүнээс Сүмбэр суманд 188, Баянтал суманд 8, Шивээговь суманд 28 бүгд 224 худаг ашиглагдаж байна.

Тус аймгийн нутагт байнгын урсгалтай Хулгар, Уулзвар, Цоорхойн булаг, Хүхээ, Цагаан Ус, Уст ханан, Шивээгийн булаг зэрэг 43 ил задгай гол горхи булаг шанд байдаг.

Уул уурхайн болон хүний үйл ажиллагаанаас болж усны төвшин буурах, булаг шанд ширгэх үзэгдэл ажиглагдаж байна.

## **Зорилт**

Усны нөөцийг зүй зохистой ашиглан хамгаалж, хүн амыг стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах технологийг нэвтрүүлж, хөдөө аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

## **Үйл ажиллагаа**

- ❖ аймгийн усны нөөцийн мэдээллийн сан бүрдүүлж, судалгаажуулна.
- ❖ Бэлчээрийн уст цэгүүдийг засварлах, нөөцөнд авах, актлах ажлыг графикийн дагуу гүйцэтгэж, эзэнжүүлэх ашиглалтыг сайжруулах
- ❖ Худгаас ус өргөх шинэ хийцүүдийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх
- ❖ Төвлөрсөн усан хангамжийн системийн шугам сүлжээнд усны алдагдал гаргахгүй байх, хэрэглэгчдийг зохистой хэрэгцээнд сургах
- ❖ Аймгийн төвийн хэрэглээний усыг төмөргүйжүүлэх, шугам хоолойг шинэчлэх, улмаар төв суурингийн усыг цэнгэгжүүлэх, зөөлрүүлэх техник технологийг нэвтрүүлэх.
- ❖ Аймгийн төвд цэвэрлэх байгууламжтай болох.
- ❖ Усны гидрохимийн лабораторитой болж, ундны усны чанарын шинжилгээг тогтмолжуулна.
- ❖ Горхи, булгуудын усны эхийг тохижуулж, тарималжуулах.

## **5.6 Аялал жуулчлалыг хөгжүүлэх**

### **Үндэслэл**

Тус аймгийн төв нь Хэрлэн голоос 90 км, Дорноговь аймгийн Халзан–Уулын рашаан сувиллаас 60 км зайд оршдог бөгөөд орон нутгийн хамгаалалттай өндөр хадан хясаагаар хүрээлэгдсэн дотор эрхтнийг анагаах увьдистай Цоорхойн рашаан, Аргаль, янгир нутагшсан Чойрын богд уул, Эртний түүхт Зүүн Чойрын хийдийн туурь, Зараа хэмээх газарт байгаа эртний түрэгийн хүн чулуун хөшөө дурсгалууд зэрэг байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой.

Мөн ойролцоох 4 аймгийн 10 орчим сумтай хиллэдэг, дээрхи аймаг сумдаас 65-200 км зайтай, авто болон төмөр замын тээвэр тогтмолжсон зэрэг нь дотоодын аялагчдыг хүлээн авах боломжтой.

## **Зорилт**



Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- Аялал жуулчлалын маршрут зохион эрх бүхий байгууллагаар батлуулж дотоод гадаадын жуулчид, аялагчдыг хүлээн авах,
- Чөлөөт бүс байгуулахтай холбогдон дотоод гадаадын аялагч, жуулчдыг хүлээн авах зочид буудал, жуулчны баазыг бий болгох,
- Байгалийн болон түүхийн дурсгалт зүйлүүдийг хамгаалах, сэргээн засварлах
- Жуулчдад зориулан орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгал зүйлс, сувинер үйлдвэрлэх, худалдаалах төвтэй болох

### **Үйл ажиллагаа**

- ❖ Аялал жуулчлалын маршрут зохион эрх бүхий байгууллагаар батлуулан, аялалыг зохион байгуулах
- ❖ Жуулчдыг хүлээн авах зочид буудал, жуулчны баазыг орчин үеийн шаардлага, зочид буудал, жуулчны баазын стандартад нийцүүлэн барьж байгуулах;
- ❖ Орон нутгийн онцлог, түүхийг сайн мэдэх, гадаад хэлний мэдлэгтэй жуулчлалыг зохион байгуулах хөтөч тайлбарлагчийг сургаж дадлагажуулах ;
- ❖ Байгалийн болон түүхийн дурсгалт газруудыг хамгаалах, сэргээх засварлах;
- ❖ Бэлэг дурсгалын зүйл, сувинер хийх санаачлагыг өрнүүлэх, худалдаалах төв бий болгох ;

## **ЗУРГАА. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ**

### **6.1 Тогтвортой хөгжлийн удирдлага, зохицуулалт**

#### **Үндэслэл**

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас байгуулсан аймгийн Тогтвортой хөгжлийн зөвлөл, түүний ажлын хэсэг гүйцэтгэв. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил нь үнэн хэрэгтээ нийгмийн гишүүн бүрийн амьдралын, байгууллага бүрийн үйл ажиллагааны хөтөлбөр, тэдгээрийн хөгжил дэвшлийн үйлсийн төлөөх үйл хэрэг учраас аймаг, сум, багийн Засаг дарга нар, тэдгээрийн Тамгын газар, албад, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд тухайн түвшиндээ уг ажлыг зохион байгуулах, түүнд биечлэн оролцох, удирдлага зохицуулалт нь нэгдмэл байх ёстой. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг бодит үр дүнд хүргэхийн тулд зөв шийдвэр гаргах, удирдан зохицуулах чадварлаг тогтолцоо онцгой шаардлагатай.

#### **Зорилт**

Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх

#### **Үйл ажиллагаа**

- Аймагт тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдлагын тогтолцоо бүрдүүлэх;
- Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн явцыг үнэлэх, хянах тогтолцоо бий болгох
- Тогтвортой хөгжлийн мэдээллийн сүлжээтэй болох;
- Орон нутагт ажиллаж буй Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, засаг захиргаа, аж ахуйн нэгж, байгууллагын удирдагчдыг тогтвортой хөгжлийн холбогдолтой төрөл бүрийн сургалт, семинарт өргөн оролцуулах;

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд төрийн бус байгууллагууд, олон нийтийг оролцуулахын тулд мэдээллийн сүлжээ, зөвлөлгөө өгөх нэгжийг байгуулж ажиллах ;

## **6.2 Хүний нөөцийн чадавхи бий болгох**

### **Үндэслэл**

Хүн ам цөөн, боловсон хүчин дутагдалтай, хүнийг хөгжүүлэх явдал хангалтгүй байна. Иймээс орчин үеийн эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, техникийн дэвшилд тулгуурлан тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, оюуны чадавхийг өндөр түвшинд хүргэх нь чухал байна. Аймгийн төв, сумдад ажилгүй байгаа мэргэжлийн боловсон хүчнүүд нь өөрсдийнхөө мэдлэг, ур чадварыг ашиглан орон нутгийн хөгжилд шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах талаар шинийг санаачилж ажиллахгүй, бэлэнчлэх сэтгэлгээ гаргаж зөвхөн ганзагын наймаагаар амь зуух хандлага давамгайлсаар. Иймээс тус аймагт иргэдийн боловсрол, соёлын түвшин, нутгийн захиргаа, аж ахуйн удирдах ажилтнуудын удирдах чадвар болон хүмүүсийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь хүний нөөцийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

### **Зорилт**

Орон нутгийн хүний нөөцийн чадавхийг бүрдүүлж, төлөвшүүлэх үр бүтээлтэй ажил эрхлэлтэд мэргэжлийн сургалтыг чухалчилж, удирдлагын болон ажлын ур чадварыг хүн бүрт олгох

### **Үйл ажиллагаа**

- Сургуулийн насны хүүхдийн сургууль завсардалтыг арилгаж, бүх иргэдийг суурь боловсролоос дээш боловсрол эзэмшүүлэх;
- Багшлах боловсон хүчний хангалт, чанарыг сайжруулах замаар сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;
- Иргэдийг амьдрах ухаанд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сургалтыг өргөжүүлэх;
- Хүүхдийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг үр дүнтэй болгох;
- Төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн байгууллага бүрийг суралцагч байгууллага болгоно;
- Төрийн захиргааны байгууллагын боловсон хүчнийг чадваржуулах, тогтвор суурьшилтай ажиллах чиглэлээр хөтөлбөр гаргаж ажиллах;
- Үр дүнтэй, өндөр үр бүтээлтэй ажилласан мэргэжилтэй боловсон хүчнийг урамшуулах тогтолцоог бий болгох;
- Төрийн захиргаа болон бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг ажлын ачаалал давхардлыг арилгах замаар зохицуулж цомхон чадварлаг аппарат бүрдүүлэх;
- Аж ахуйн удирдагчдын менежментийг сайжруулах, бэлтгэх, давтан бэлтгэх сургалт зохион байгуулах;
- Хүмүүсийн боловсрол, хүмүүжлийн түвшинг өндөржүүлж, өөрийгөө болон өрх гэрээ хөгжүүлэх, арга зүйг эзэмшүүлэх;

## **6.3 Тогтвортой хөгжлийн эрх зүйн орчин**

### **Үндэслэл**

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

Тогтвортой хөгжлийн асуудал нь орон нутагт шинэ ойлголт, үйл ажиллагаа учир төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн онцлог, хүн амын нутагшил, суурьшил, зан заншил зэрэгт тулгуурлан байгаль орчныг хамгаалах талаар төв, орон нутгийн төр, захиргааны байгууллагын тогтоол, шийдвэр нь тогтвортой хөгжлийн зарчим, зорилгыг хэрэгжүүлэх шаардлага хангахгүй байна.

### **Зорилт**

Тогтвортой хөгжлийн зарчим, зорилго, механизмын үйлчлэлийг иж бүрэн, саадгүй хангах, орон нутгийн эрх зүйн орчинг үндэсний түвшинтэй уялдуулан бий болгох.

### **Үйл ажиллагаа**

- z Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, үүнтэй холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ орон нутгийн онцлогийг харгалзсан эрх зүйн орчин бий болгох;
- z Тогтвортой хөгжлийн талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд, нийгмийн бүлэглэлүүдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, зохицуулалтын механизм, хөшүүрэг бий болгон хэрэглэх;
- z Тогтвортой хөгжлийн хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах, тэдэнд зохих мэдлэг олгох;
- z Тогтвортой хөгжлийн талаархи шийдвэрийн биелэлтэд бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, төрийн бус байгууллага, олон нийтийн төлөөлөгчид байнгын хяналт тавих, идэвхитэй оролцох дэг журам бий болгон мөрдөх;
- z Тогтвортой хөгжлийн талаархи эрх шийдвэрийг мэдээлэх, сурталчлах, хэрэгжүүлэх үүргийг аймаг, сум, багийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөр, төрийн албан хаагчдын ажлын хуваарьт оруулж, биелэлтийг шалган дүгнэхэд нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, захиргааны хяналтыг чиглүүлэх;.

## **6.3 Тогтвортой хөгжлийн мэдээлэл, сурталчилгаа**

### **Үндэслэл**

Орон нутагт тогтвортой хөгжлийн нийгэм болон байгаль орчин%, шинжлэх ухаан, технологийн талаар дэлгэрэнгүй статистик мэдээлэл үгүйлэгдэж байна. Тогтвортой хөгжил нь түүхэн урт хугацааны урт хугацааны, тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа мөн бөгөөд аливаа нэгэн зорилгын талаар шийдвэр боловсруулахаас эхлэн хэрэгжиж дуусах хүртэлх бүхий л шатанд мэдээллээр цаг тухайд нь, орчин үеийн түвшинд хангах чухал шаардлага гарна.

Тогтвортой хөгжлөөс гадуур аж ахуйн нэгж, байгууллага иргэн байхгүй учир бүгд л мэдээллийг хэрэглэгч ба түгээгч болж, мэдээллийн нээлттэй тогтолцоонд ажиллах учиртай болно.

### **Зорилт**

Тогтвортой хөгжлийн мэдээллийн үндэсний сүлжээний хүрээнд орчин үеийн холбоо, техник, технологид тулгуурласан мэдээллийг цуглуулах, үнэлгээ өгөх, боловсруулах, тараах, хэрэглэсэн мэдээллийн үр дүнг тооцох үр өгөөжтэй тогтолцоог орон нутагт бүрдүүлэх.

### **Үйл ажиллагаа**

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот

- μ Аймгийн хөгжлийг үнэн зөв харуулах үзүүлэлтийг гаргахын тулд хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчны холбогдолтой статистик мэдээний орон нутгийн сан бий болгох;
- μ Мэдээлэл, харилцааны дэвшилтэт технологи, сансрын холбоог ашиглах;
- μ Хот хоорондын холбооны сүлжээ байгуулж, мэдээллийг түргэн шуурхай ашиглах талаар тодорхой үе шаттай арга хэмжээ авах;
- μ Мэдээлэл үүсгэх, эрж олох, харилцан дамжуулах, боловсруулах, үнэлэлт, дүгнэлт өгөх, ашигласан мэдээллийн үр дүнг тооцох хийгээд эдгээр үйл ажиллагаанд хэрэглэх техник хэрэгсэл, арга технологид хүнээ чөлөөтэй сургах, тэдний сонирхлыг татах, ашиг сонирхолд нь нийцүүлэх тогтолцоотой болох;

#### **6.4 Тогтвортой хөгжилд нутгийн уугуул иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоо**

##### **Үндэслэл**

Нутгийн уугуул иргэд нь газар нутгийхаа олон жилийн түүхэн явдал, зан заншил, ёс суртахуун, аж ахуй эрхлэх арга барил, байгаль орчин, түүний нөөц, баялагийн талаар үе дамжсан уламжлалт мэдлэгийг хуримтлуулсаар ирсэн. Тэд нутаг орноо хөгжүүлэхэд хамгийн ашиг сонирхлоо илэрхийлдэг. Орон нутагт ажиллаж байгаа төрийн бус байгууллага нь олон нийтийг өргөнөөр хамарсан байдаг тул аймгийн хөгжлийн асуудалд ард түмнийг татан оролцуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

##### **Зорилт**

Нутгийн олон түмэн, уугуул иргэдийн сэтгэл, ашигт сонирхол, мэдлэг, хөрөнгө, хүчний чадавхийг тогтвортой хөгжилд эн тэргүүнд оролцуулах

##### **Үйл ажиллагаа**

- Аж ахуйгаа сэргээх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, дэд бүтцээ сайжруулах, байгаль орчноо унаган төрхөөр нь хадгалах, хөндөгдсөн, эвдсэн, элэгдэлд орсон байгалийг нөхөн сэргээх, нөөц баялагийг нь үр ашигтай ашиглан амьдрал ахуйгаа дээш татах хэрэгт нутгийн ард иргэдийг эн тэргүүнд оролцуулах;
- Байгаль орчноо хүндлэн дээдэлдэг ардын уламжлалт зан заншлыг нутгийн уугуул иргэдээр дамжуулан олон нийтэд өвлүүлэх;
- Тогтвортой хөгжилд төрийн бус байгууллагын идэвхитэй оролцох бололцоог бүрдүүлэх, төрийн бус байгууллагаас тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих механизм бий болгох;
- Тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй холбогдсон дэд хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулахад төрийн бус байгууллагыг шууд оролцуулах, тэдгээрийн санал, санаачлагыг дэмжих, мэдээллэр харилцан үйлчлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Боловсрол олгох, ядуурлыг арилгах, ажлын байр гаргах, байгаль орчныг сэргээх, хамгаалах талаархи төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны дэг журам бий болгон мөрдөх;
- Аймаг, сумын тогтвортой хөгжлийн хэтийн бодлого, чиглэлийн талаар ард түмэнд мэдээлэл хүргэх, ард олны санал авах, тэдгээрийн хүчийг дайчлан оролцуулахад орно нутгийн төр, захиргааны үүрэг ролийг нэмэгдүүлэх, тэдгээрийн менежментийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн төлөвшүүлэх;

#### **6.5 Тогтвортой хөгжил дэх бизнес эрхлэгчид, ажилчид, эрдэмтдийн оролцоо**

## Үндэслэл

Эдийн засгийн шинэтгэлийн өнөөгийн нөхцөлд малчид гол төлөв амиа аргацаах хувийн хэдэн малтай, урьд өмнө ажиллаж байсан үйлдвэрийг хувьчилж, дампууруулж, тарааснаас ажилчдын дийлэнх нь ажилгүй буюу мэргэжлийн бус хөдөлмөрөөр ам бүлээ дөнгөн данган авч явж буй, орон нутгийн олонхи залуус ганзагын наймаа хийж буй ерөнхий дүр төрх нийгмийн гишүүдийн үүрэг, байр суурийг тодорхойлж байна. Бизнес эрхлэх сонирхолтой иргэд, байгууллага шаардлагатай нөөц хуримтлал буй болгож чадахгүй байгаагаас тэдэнд хөрөнгө, санхүү, менежментийн бэрхшээл тулгарч байна.

## Зорилт

Бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжиж, тэднийг хүрээлэн буй орчиндоо халгүй техник технологиор үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломжийг бүрдүүлнэ.

## Үйл ажиллагаа

- Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг багасгахад чиглүүлсэн ажлын байр бий болгоход тэргүүн ээлжинд хөрөнгө, нөөц ашиглах;
- Ажил эрхлэлтэд мэргэжлийн сургалтыг удирдлага болгож, ажлын ур чадварыг хүн бүрт эзэмшүүлэх;
- Хүмүүсийг эрүүл, цэвэр орчинд аж төрж амьдрах, ажиллах, сурч боловсрох бололцоо, нөхцлийг бий болгоход төрийн бус байгууллагын үүрэг, оролцоог сайжруулах;
- Ажлын байрны эрүүл ахуйн байдал, хөдөлмөр хамгаалал, амьжиргааны зохистой арга барилд ажилчдыг сурган дадлагажуулж, мэргэшүүлэх;
- Бизнес эрхлэгчдэд хүрээлэн буй орчинд халгүй техник, технологийг ашиглах, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж иргэдийн хэрэгцээг хангах;
- Бизнес эрхлэгчид нь тогтвортой хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн бодитой туслалцаа үзүүлэх;
- Бизнес эрхлэгчдээс бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ хаягдалгүй технологи хэрэгдэх, байгалийн баялагийг ашиглах, нөхөн сэргээх, хог хаягдлыг цэвэрлэх, дахин боловсруулах, хүрээлэн буй орчныг хамгаалахад оруулсан хувь нэмрээр нь урамшуулал олгох;
- Тогтвортой хөгжлийн хөтөлбөр боловсруулахад нутгийн зөвлөлийн эрдэмтэд, мэргэжилтний зөвлөмж, саналыг авч байх. Судалгаа шинжилгээний ажилтнуудаас аймаг орныхоо байгалийн баялаг, нийгмийн хөгжлийн түүхэн үе шатуудын талаар гаргасан судалгаа, мэдээллийг өргөн ашиглах;
- Аймгийн хөгжлийг тогтвортой болгоход гол нөлөө үзүүлэхүйц шинжлэх ухааны үндэстэй арга, өндөр үр ашигтай техник, технологийг нэвтрүүлэх талаархи олон түмний санал, үзэл бодлыг төр, захиргааны байгууллага тусгайлан авч үзэж байх журам тогтоох;

## 6.6 Санхүүгийн эх үүсвэр

### Үндэслэл

Аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үлэмж хэмжээний хөрөнгө шаардагдах нь зайлшгүй. Одоогийн байдлаар орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэр хүрэлцэхгүй байна. Тогтвортой хөгжлийн санхүүгийн асуудлыг шийдвэрлэх гол эх үүсвэр нь аймгийн дотоодын хөрөнгийн нөөц (аймгийн төсвийн хөрөнгө, аж ахуйн нэгж,

Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хот байгууллагаас тогтвортой хөгжилд зарцуулж байгаа хөрөнгө), улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад орнууд, тэдгээрийн болон олон улсын байгууллагын төсөл, тусламж, зээлийн хөрөнгөөс бүрдэх төлөвтэй.

### Зорилт

Аймаг, сумын тогтвортой хөгжлийн санг бий болгож, үр дүнтэй ашиглах.

### Үйл ажиллагаа

- ◆ Тогтвортой хөгжлийн санг арвижуулах;
- ◆ Тогтвортой хөгжлийг дэмжихэд аймгийн түвшинд зээл мөнгөний бодлогоор дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийх зэрэг эдийн засгийн хөшүүргүүдийг өргөн ашиглах;
- ◆ Орон нутагт хэрэгжүүлж буй олон улсын хөтөлбөрүүдийн санхүүгийн тусламж дэмжлэгийн үр ашгийг сайжруулах;
- ◆ Засгийн газрын бус байгууллагуудад олон нийтийн хандиваар дамжуулан сан бүрдүүлэхэд шаардагдах нөхцлийг хангах;
- ◆ Орон нутгийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- ◆ Тогтвортой хөгжилд дорвитой нэмэр хандив оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах;
- ◆ Аймаг, сум хөгжүүлэх, нийгмийн даатгалын, өрхийн өмьжиргааны чадавхийг дэмжих сангуудын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх. Тогтвортой хөгжлийн төслүүдийг шалгаруулахдаа сангаас олгосон зээлийг эргүүлж төлөх чадварыг гол үзүүлэлт болгох;

*Хэвсралт 1*

#### Хүн амын өсөлтийн төлөв

	1991 он	1996 он	2000 он	2010 он	2020 он
Хүн амын тоо	11509	12084	13215	25365	30184
Төрөлт	393	275	363	693	830
Нас баралт	71	99	79	152	181
Хүн амын ердийн цэвэр өсөлт	316	176	284	546	649

*Хэвсралт 2*

#### Хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний хэтийн төлөв

Үзүүлэлт	Нэг хүний норм	Хэмжих нэгж	2000 он	2010 он	2020 он
Хүн ам			12342	23690	28190
Нэг хүнд ногдох илчлэг	3136 ккал		3100	3120	3130
Мах, махан бүтээгдэхүүн	80 кг	тн	987,3	1895,2	2255,2
Сүү, сүүн бүтээгдэхүүн	200 кг	тн	2468	4738	5638

## Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөглөбөр, 2003, Чойр хог

Цөцгийн тос	7 кг	тн	86,4	165,8	197,3
Загас, загасан бүтээгдэхүүн	2 кг	тн	24,7	47,4	56,4
өндөг	80ш	мянган. ш	987,3	2895,2	2255,2
Сахар, чихрийн зүйл	30 кг	тн	370,2	710,7	845,7
Гурил, гурилан бүтээгдэхүүн	120 кг	тн	1481	2842,8	3382,8
Жимс, жимсгэнэ	45 кг	тн	555,3	1066	1269,5
Төмс	80 кг	тн	987,3	1895,2	2255,2
Хүнсний ногоо	80 кг	тн	987,3	1895,2	2255,2
Идэшний тос	4кг	тн	49,4	94,8	112,8
Ургамлын тос	4 кг	тн	49,4	94,8	112,8
Будаа	20 кг	тн	246,8	272,8	583,8

Хавсралт 3

## Мал сүргийн өсөлтийн хэтийн төлөв

үзүүлэлт	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1991	93769	349	6167	7480	67838	11935
1996	110740	458	10295	10924	59939	29124
2000	125765	465	11600	13900	65800	34000
2010	151780	480	13500	19300	80500	38000
2020	164490	490	16000	23000	85000	40000

Хавсралт 4

## Хөдөлмөрийн нөөцийн хэтийн төлөв

	1991	1996	1997	2000	2010	2020
Хөдөлмөрийн нөөц	5814	5926	5677	7884	15833	19395
Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн ам	5597	5652	5677	7730	15523	19015
Тэтгэвэрт гарсан ажиллаж байгаа хүн	200	274	5762	154	310	380
Ажиллаж байгаа хүүхэд	23					
Нийт хүн амд хөдөлмөрийн нөөцийн эзлэх хувь	50,5	49,0	47,7	59,6	62,4	64,2
Ажиллагсад, бүгд	4852	2708	3820	5124	10291	12606
Хөдөө аж ахуйд						
тоо	685	167	259	358	751	1008
хувь	14,1	6,1	6,8	7,0	7,3	8,0
Уул уурхай олборлох аж үйлдвэрт						
тоо	204	354	504	804	1646	2166
хувь	4,2	13,0	13,2	15,7	16,0	17,2
Цахилгаан эрчим хүч						
тоо	315	215	275	379	833	1071

## Говьсүмбэр аймгийн XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2003, Чойр хог

	хувь	6,4	7,9	7,2	7,4	9,1	8,5
Барилга	тоо	74	94	133	210	473	605
	хувь	1,5	3,4	3,5	4,1	4,6	4,8
Тээвэр, холбоо	тоо	275	896	859	625	1389	1764
	хувь	5,6	25,0	22,5	12,2	13,5	14,0
Боловсрол	тоо	359	321	454	614	1265	1689
	хувь	7,3	11,6	11,9	12,0	12,3	13,4

Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ	тоо	424	247	343	445	833	1071
	хувь	8,7	9,1	9,0	8,7	8,1	8,5